



# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.09.26, ЛХАГВА ~ №189 (988)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

**Дэд төвийг тойруулан 10 мянган айлын орон сууц барина**

Дэд төвүүд барих ажлыг ирэх жил бүрэн дуусгахаар төлөвлөжээ. > 4

**FT ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД ТАНД ХҮРЧ БАЙНА > 9-10**

**Таны хүүхдийг аюул хаана ч отож байна**

Хүүхдэд ээлгүй нийслэлийн бодит төрхийг гэрэл зургийн дуранд буулгалаа. > 8

ZGM DAILY

**FULL ENGLISH PAGE INSIDE**

> 7

**ОНЦЛОХ**

**УЛС ТӨР**

**Монгол, Азербайжаны бизнесийн шууд харилцааг хөгжүүлэх талаар ярилцав.**  
**2019 оны мөнгөний бодлогын төсөлд инфляцыг найман хувьд барихаар тусгажээ.**  
**УДШ Н.Энхбаярыг МАХН-ын даргаар бүртгээгүй гэж УИХ-ын гишүүн О.Баасанхүү хэлэв.**  
**У.Хүрэлсүх "Хар тамхины тэмцэх дэлхийн уриалга"-д МУ нэгдэж буйг илэрхийллээ.**

**ЭДИЙН ЗАСАГ**

**Сүүлийн нэг жилд дотоодоос долоон компани 28 тэрбум төгрөг босгожээ.**  
**МИАТ нойтон түрээсийн нислэгээ Европын 50 гаруй чиглэлд амжилттай гүйцэтгэв.**  
**Зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэр төрөл өргөжиж, зах зээл тэлж байна**  
**Топ 20 индекс 19912.97 нэгж болж 0.24 хувиар өсөв.**



## АРХАГШСАН АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРАЛ БҮХ ЗОВЛОНГИЙН ҮНДЭС



Нийгэмд аюулын харанга дэгдээж буй хүүхдийн осол, эндэгдэл, агаарын бохирдол, боловсролын хүртээмж гээд бүх асуудлын цаана ядуурал нуугдаж байна. Тиймээс хуримтлагдсан энэ бүхний үндэс болсон ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад төрийн бодлогыг зоригтой чиглүүлэх цаг нэгэнт болжээ. > 3

**НИЙГЭМ**

**УЦУОШГ: Лхагва гарагаас ихэнх нутгаар цас ихээр орж, зам даваа хаагдаж болзошгүй.**  
**Нийслэлд сургууль, цэцэрлэг барих байршлын газар чөлөөлөлт 94 хувьтай байна.**  
**Ирэх сарын 1-нээс Монгол, Хятадын хилийн боомтууд гурван хоног амарна.**  
**2013 оны есдүгээр сар хүртэл олгосон дипломат, албан паспортыг хүчингүйд тооцно.**

**ДЭЛХИЙ**

**НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулган Нью-Йоркт эхэлж байна.**  
**ЕХ дээд шүүхийн эрхийг хязгаарласан асуудлаар Польшийг шүүхэд өгчээ.**  
**Instagram-ыг үндэслэгч К.Систром, М.Кригер нар Facebook-ыг орхиж буйгаа мэдэгдэв.**  
**Сингапурт Uber, Grab хоёрыг өрсөлдөөний эсрэг хэлцэл хийсэнд буруутган торгожээ.**

**ЦАГ АГААР**

**УЛААНБААТАР**  
 2018.09.26  
  
 19° | 8°  
**БАГА ЗЭРГИЙН ХУР ТУНАДАС**  
 ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ 6 ДУГААР НҮҮРЭЭС УНШИВНА УУ.  
  
 Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

**ЗГМ: СЭДЭВ**

### Дөрвөн өрх тутмын нэг нь огт баталгаагүй хүнс хэрэглэдэг

**Б.Баярмаа**  
 @bayarmaaZGM

Монголчуудын хүнсний аюулгүй байдал алдагдсан уу гэж захын хүнээс асуухад хөмсгөө атируулан санал нийлж буйгаа хэлж байна. Гэвч эрүүл хүнс хэрэглэе гэвэл гарын таван хуруунд багтах цөөн хэдэн хүнс л сонгохоос аргагүй байгаа. Манай улсад дотоодын хэрэгцээгээ 50 хувиас дээш хангаж буй салбарыг тоолбол мах, сүү, цагаан идээ, гурил, төмс гээд гарын таван хуруунд багтчихаж байна. Харин

үлдсэн нь импортоос, тэр дундаа БНХАУ-ын бүтээгдэхүүнээс хараат. Манай улс төрөл бүрийн будаа, буурцагт ургамлыг 100 хувь импортолж хэрэглэдэг. Харин жимс, жимсгэний 92.9, хүнсний тосны 92.7, өндөгний 49.7, хүнсний ногооны 43.5 хувийг импортоор хангадаг. Гэтэл манайд хүн хүч дутмаг гэсэн шалтгаанаар хил гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалт маш сул байдгийг хэн хүнгүй мэднэ.

> 5



### Газрын тосны үнэ дөрвөн жилийн дээд түвшинд хүрэв

**Анжли Равал**

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын шаардлагыг үл харгалзан дэлхийн олборлогчид олборлолтоо цаашид өсгөхгүй гэж шийдсэн. Гэвч үүний дараа буюу даваа гарагт газрын тос баррель нь 81 ам.долларт хүрсэн нь сүүлийн дөрвөн жилд тохиогоогүй өндөр үнэ боллоо. Саудын Араб тэргүүтэй ОПЕК, ОХУ тэргүүтэй тус картелийн бус олборлогч нар өнгөрсөн долоо хоногт Алжирт чуулсан уулзалтаараа газрын тос олборлолтыг зургадугаар сард тохиролцсон түвшнээс

хэтрүүлэхгүй байхаар санал нэгдэв. Ираны эрчим хүчний салбарт тавьсан АНУ-ын хориг 11 дүгээр сараас хэрэгжих ёстой. Гэсэн хэдий ч уг хориг хэдийн Ираны газрын тосны экспортод цохилт болж, санхүүгийн шийтгэлээс эмээсэн худалдан авагч нар тус улсаас нефть худалдан авалтаа танаж эхлэв.

“ОПЕК болон бусад олборлогч үйлдвэрлэлээ ихэсгэхээс татгалзсаны үр дүн зах зээлд илэрч буй хэрэг” хэмээн Commerzbank-ны Карстен Фриц тайлбарлаж байна.

> 9

**ЭДИЙН ЗАСАГ**


### Нүүрсний компаниуд бизнесийг их наядаар тэтгэдэг

**Б.Баяртогтох**  
 @bayartogtokhZGM

Уул уурхайн төслүүдийн эдийн засгийн ач холбогдлыг үнэлэхдээ бид голчлон нягтлан бодох бүртгэлийн үндсэн дээр тооцсон ашиг орлогын хуваарилалтад анхаардаг тал бий. Гэвч энэ нь бодит байдал дээр тухайн төслийн нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн өчүүхэн хэсэг юм. Үнэн хэрэгтээ Монгол Улс төслийн өгөөжийн салаа урсгал бүрээс тодорхой үнэ цэнэ хүртдэг. Үүнийг их, бага гэж л ангилж болох юм. Зөвхөн төсөвт бүрдүүлж буй татвар, хураамж, төлбөрөөр уул уурхайн төслийн өгөөж хязгаарлагдахгүй. Харин цалин хөлс, ханган нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн төлбөрүүд, орон нутагт бий болж буй худалдаа, үйлчилгээ, ажлын байр, үйлдвэрлэлээр хэмжих нь илүү оновчтой болов уу. Хамгийн энгийнээр хэлэхэд уурхайн үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай худалдан авсан бараа үйлчилгээ нь эргээд бизнес цэцэглэх үүд хаалгыг нээдэг. Тухайлбал, эрчим хүч, химийн бодис, ачааны машины дугуй, ажлын хувцас гээд энэ болгоныг аж ахуйн нэгжээс худалдаж авснаар эргээд хувийн хэвшилд ашиг, орлого болж очдог.

> 12

**ЗГМ: ИНФОГРАФИК**



| АЛТ              | ЗЭС           | 10-ЧИНГИС БОНД | ХУРАЛДАЙ БОНД   | ГЭРЭГЭ БОНД     | АМ.ДОЛЛАР | ЮАНЬ   | РУБЛЬ |
|------------------|---------------|----------------|-----------------|-----------------|-----------|--------|-------|
| 1204.20<br>0.02% | 6353<br>0.16% | 94.50<br>0.14% | 108.32<br>0.13% | 95.210<br>0.15% | 2,533.95  | 368.72 | 38.42 |



## Улс төр

# АТГ цаг үеийн асуудлаар МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

**АТГ шалгаж буй  
сэжигтний гэрээс  
1.3 сая ам.долларыг  
бэлнээр хураан  
авчээ**

Г.Билгүүн  
ЗГМ

АТГ цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой зарим хүнд холбогдох асуудлыг дэлгэлээ. Тухайлбал, Зам тээврийн яам, Улаанбаатар төмөр зам, БСШУСЯ, Гаалийн ерөнхий газар зэрэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой томоохон аж ахуйн нэгжийн удирдлагатай холбоотой хэргийг шалгаж эхэлсэн байна.

АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү “ЗТЯ-ны дэд сайд асан Х.Ержаны хүүхэд Канзасын их сургуульд агаарын зайн инженер мэргэжлээр, ИНЕГ-ын Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны дарга Б.Цогоогийн хүүхэд ОХУ-ын Сибирийн нисэхийн академид агаарын хөлгийн техникийн ашиглалтын мэргэжлээр, “УБТЗ” ХНН-ийн Орлогч дарга асан Ч.Эрдэнэдалайгийн хүүхэд Австрали улсын Свинборны технологийн их сургуульд



Б.Батдорж / ЗГМ ©

нисэхийн менежмент чиглэлээр суралцахаар төлбөрөө ИНЕГ-аар төлүүлсэн” гэлээ.

Дөрвөн жилийн хугацаанд тус газар 9.8 тэрбум төгрөгийг гадаадын сургуулийн төлбөрт шилжүүлжээ.

Түүнчлэн ГЕГ-ын дарга Б.Асралт албан тушаалаа урвуулан ашиглаж ашиг сонирхлын зөрчилтэй Ч.Балдандорж, С.Хавал нарыг зарим аймгийн

гаалийн даргаар томилсон байна.

Тэгвэл БСШУСЯ цохолт хийж, 41 хүүхдийг Нэгдүгээр сургуульд оруулсан нь мөн л албан тушаалаа ашигласан хэрэг тул, АТГ шалгаж байгаа аж.

Тус газар Зам тээврийн хөгжлийн яамны Тээврийн ухаалаг систем, өгөгдлийг хариуцсан мэргэжилтнүүдтэй холбоотой хэрэг, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх


**ИНЕГ 9.8 тэрбум  
төгрөгийг  
гадаадын  
сургуулийн төлбөрт  
шилжүүлжээ**

газрын шийдвэр гүйцэтгэгч улсад 1.1 тэрбум төгрөгийг хохирол учруулсан хэрэг, “Монголросцветмет” ХХК-ийн ерөнхий захирал албан тушаалаа урвуулан ашиглаж хоёр сая гаруй ам.доллар буюу 4.5 тэрбум төгрөгийн их хэмжээний хохирол учруулсан хэрэг зэргийг шүүхэд шилжүүлэхээр прокурорын байгууллага руу явуулжээ. Мөн АТГ-т шалгагдаж байгаа

сэжигтний гэрээс их хэмжээний буюу 1.3 сая ам.доллар хураан авсан талаар мэдэгдлээ. АТГ-ынхан энэ хэргийн талаар “Хураан авсан их хэмжээний мөнгийг юунд зарцуулах гэж байсан болон гарал үүслийг судалж, нарийвчлан шалгаж байна. Сэжигтний нэрийг зарлахыг прокуророос зөвшөөрөөгүй учир хэлэх боломжгүй” гэсэн хариулт өглөө. [ЗГМ]

## ЕРӨНХИЙЛӨГЧ

### Ерөнхийлөгч Х.Баттулга Азербайжаны Ерөнхийлөгчтэй уулзлаа



БНАУ-ын тал Монголын бараа, бүтээгдэхүүнийг Азербайжанаар дамжуулж Ойрх Дорнодын улсуудад нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлжээ.

Бүгд Найрамдах Азербайжан улсад ажлын айлчлал хийж буй Ерөнхийлөгч Х.Баттулга тус улсын Ерөнхийлөгч Илхам Алиевтэй ганцаарчилсан болон өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй уулзалт хийжээ.

Хоёр улсын Ерөнхийлөгч Монголын нутаг дэвсгэрээр дамжин, бусад орнуудын зах зээлд хамтран гарах, бүс нутгийн хөгжилд идэвхтэй оролцоотой байх талаар ярилцлаа. Түүнчлэн Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргахад ложистикийн дэмжлэг

үзүүлэх, энэ чиглэлд хамтран ажиллах боломжийг харилцан судлахаар тохиролцсон байна.

Харин өргөтгөсөн уулзалтын үеэр Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол, Азербайжаны харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар нь баяжуулах өргөн нөөц боломж байгааг хэлжээ. Мөн хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчид хоорондын шууд харилцааг хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хүсэв. Хариуд нь БНАУ-ын тал Монголын бараа, бүтээг-

дэхүүнийг Азербайжанаар дамжуулж Ойрх Дорнодын улсуудад нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлжээ. Түүнчлэн Монгол Улсаас мах болон арьс шир гэх мэт малын гаралтай бүтээгдэхүүнийг Азербайжан улс импортлох, Монгол Улсад 300 орчим хүнийг ажлын байраар хангахуйц ноос, ноолуур боловсруулах болон хивсний үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт хийх, технологийн шийдлийг Азербайжан улсаас авах асуудлыг нухацтай судлахаар тохирчээ. [ЗГМ]

## ТӨСӨЛ

### Н.Баяртсайхан: 2019 онд инфляцыг найман хувьд барина

Б.Сэлэнгэ  
ЗГМ

Монголбанк 2019 онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барилаа.

Ирэх оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцыг энэ онтой адил найман хувьд тогтворжуулах зорилт хадгалагдаж байгааг Монгол-банкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан мэдээллээ. Мөн дунд

хугацаанд зургаан хувьд тогтворжуулахаар зорьжээ. Түүнчлэн гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх бодлогоо үргэлжлүүлэх шаардлагатай гэв. Гадаад валютын албан нөөц долдугаар сарын байдлаар 2.9 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн үзүүлэлт болж байна. Харин инфляцын түвшин наймдугаар сарын байдлаар зургаан хувьтай байгаа нь

зорилтог түвшнээс хэтрээгүй үзүүлэлт юм.

Ирэх оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх хүрээнд дөрвөн арга хэмжээ авахаар болсон байна. Тухайлбал, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, финтекийг хөгжүүлэх, чанаргүй зээлийг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах зэрэг зохицуулалтууд тусгажээ. [ЗГМ]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.09.26-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 13 дугаар байрны дээврийн засварын ажил”  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-18/0093

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендер оролцогчдоос “**Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 13 дугаар байрны дээврийн засварын ажил**”-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** туршид хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:  
**1.** Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:  
Сүүлийн 2 жилийн (2016, 2017 он) борлуулалтын дундаж орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

**2.** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:  
Тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

**3.** Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:  
Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

**4.** Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:  
Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд барилга байгууламжийн дээврийн ажил болон түүнээс дээш гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм  
Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:  
**1. 1.2.1.** 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш эсвэл

ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш.

**2. 1.2.6.** Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв болон түүнээс дээш эсвэл ЗТ-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв болон түүнээс дээш.

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

**1. 2.1.1.** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт болон түүнээс дээш, эсвэл БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил болон түүнээс дээш.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. Шаардахгүй.

Тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 15 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 15 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.  
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810**



# Нийтлэлчийн булан

ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ФОРУМ 2018

**Төр өөрөө  
ажилгүйдэл,  
ядуурал руу ард  
иргэдээ түлхдэг**

Г.Байгал  
@baigalZGM

Ажилгүйдэл, ядуурал нийгмийг нэлд нь нэрвээд байна. Улс орны хөгжлийг хөмрүүлж буй энэ хос чөдөр Монголын нийгэмд хэрхэн гүн нэвчсэнийг хэдхэн баримтаар хүргэе. Эдүгээ монгол гурван хүн тутмын нэг нь ядуу, сарын 45 мянган төгрөг буюу өдрийн 1350-хан төгрөгөөр өл залгаж байна. Монгол Улсын хөдөлмөрийн насны 130 мянган хүн ажилгүй, төрөөс хайр халамж горьдон, шар нар, бор хоногийг өнгөрөөсөөр. Ялангуяа, эх орны хөгжлийг нуруун дээрээ үүрэх



Эдийн засгийн тоон өсөлт иргэнд бодитоор наалдахад хугацаа хэрэгтэй болдог байна. Харин тогтвортой бус, уул шиг өсгөж, уруудсан эдийн засаг нь ядуурал, ажилгүйдлийг бууруулж, цалин хөлсийг нэмдэггүй байна.

С.Батсайхан / ЗГМ©

# Архагшсан ажилгүйдэл, ядуурал бүх зовлонгийн үндэс



учиртай 30-39 насныхан ядууралд гүн шигдсэн. Ажилгүй гурван хүн тутмын хоёр нь 40-өөс доош насны бие эрүүл, ухаан саруул идэр нэгэн байна. Монголын хөгжлийг сэвхийтэл татах учиртай залуус маань өнөөдөр ажилгүйчүүдийн армийг түүчээлж, амьдралын баталгаажих түвшнээс доогуур иргэдийг манлайлж байна.

Монгол Улс сүүлийн 30 орчим жил хөгжлийн дөнгө болсон ажилгүйдэл ядууралтай тэмцээр ирлээ. Бүр ганцаараа бус Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран зүтгэсэн.

Дэлхийн банк 1995 онд Монгол Улсын ядуурлын түвшний албан ёсны анхны судалгааг хийжээ. Одоогоос 20 гаруй жилийн өмнө манай улсын ядуурлын түвшин 35, ажилгүйдэл 5.5 хувьтай байсан хэмээн Дэлхийн банкны шинэжээчид тайландаа дурджээ. Тэгвэл үүнээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ. Үндэсний статистикийн хорооны

тооцоогоор энэ оны хоёрдугаар улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 7.5, ядуурлын түвшин 29.6 хувьтай байна. Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш ядуу монгол хүний тоо буурсангүй. Харин ч ажилгүйдэл хэмээх хөгжлийн шинэ дөнгөтэй дөрөө харшин, дээш цойлсоор.

Үүгээр ч зогсохгүй статистикийн байгууллагаас танилцуулдаг энэ тоон дүнгийн ард ч ажилгүйдэл нуугддаг. Технологийн шинэчлэл, улс төрөөс үүдсэн бүтцийн өөрчлөлтийн улмаас хөдөлмөрийн зах зээлд далд ажилгүйдэл хүрээгээ тэлж, цалин авдаг атлаа ажил хийдэггүй, илүүдэл ажилчдын тоо нэмэгддэг байна. Хуурай тооны ард нуугдсан, манай улсын бодит ажилгүйдэл 25 хувьд хүрснийг хэдэн жилийн өмнө нэгэн олон улсын байгууллага судалсныг саяхан албаны эх сурвалж дурдаж байсан.

Энэ “гашуун” тоо үндэслэлтэй болохыг баталсан ганцхан жишээ хүргэе. Төрийн албаны таван

хүн тутмын нэг нь дарга эсвэл захиргааны албан тушаалтан байна. Манай төрийн албанд 22 мянган дарга, захиргааны ажилтан байгааг Төрийн албан зөвлөлийн тайлангаас харж болно. 2017 оны байдлаар манай төрийн бүх шатны албан хаагчдын тоо 3000-аар өсөж, 192 мянгад хүрсэн. Үүний 130 мянгыг эмч, багш зэрэг үйлчилгээний албан хаагчид эзэлж буй бол бусад нь улс төрийн болон захиргааны, тусгай албаны албан хаагчид. Гэтэл хүн амын тоогоор Монголтой эн тэнцүү Албани, Катар зэрэг орны төрийн албан хаагчдын нийт ажиллагсдын тоонд эзэлж буй хувь хэмжээ манай улсынхаас мэдэгдэхүйц бага байна. Ер нь хуруугаа бүртгүүлж цалин авдаг, төрийн ажлыг амин хувийнхтайгаа хавсран хийдэг, технологийн дэвшлийн улмаас хийх ажилгүй болсон, мэдлэг ур чадвараараа гологдсон хэдний ч суудал бөглөдөг гээд хөдөлмөрийн зах зээлийн шударга бус жишээг та хэр мэдэх вэ.

1995 оноос хойш Монголын эдийн засгийн хэмжээ 40 дахин томорч, улсын төсөв 50 дахин тэлжээ. Өдгөө найман их наяд төгрөг шүргэж буй Монгол Улсын төсөв 1995 онд 144.5 тэрбум төгрөгөөр л хэмжигдэж байсан гэвэл та итгэх үү. Одоогийн ганц яамны эсвэл нэг сайдын захиран зарцуулах зардалд ч хүрэхгүй энэ мөнгөөр Монгол Улс бүтэн жил бүхнийг зохицуулж байсан гээд бод доо. Сүүлийн 30 орчим жил Монголын эдийн засаг ийнхүү танигдахын аргагүй болтлоо томорсон атал ажилгүйдэл, ядуурал буурсангүй. Харин ч архагшиж, нийгэм, эдийн засгийн шүдний өвчин болсон ажилгүйдэл, ядууралд ард түмэн дасаж дөжрөөд байна.

Ядуурлыг ажилгүйдэл, ажилгүйдлийг эдийн засгийн тогтвортой өсөлт арилгаж чадна. Тэгвэл ажилгүйдэл, ядуурлын аль алиныг нь анагаах эдийн засгийн тогтвортой өсөлт Монголд бий бил үү. Сүүлийн хэдэн жил Монгол

Улсын эдийн засаг хасах 1.3 хувиас нэмэх 17.3 хувь хүртэл огцом хэлбэлзлээ. Гэтэл олон улсын жишгээр эдийн засгийн аливаа өсөлт тодорхой цаг хугацааны дараа, өөрөөр хэлбэл, нэлээд хожуу буюу 1-2 жилийн дараа иргэнд хүрч наалддаг байна.

## Манай улсын бодит ажилгүйдэл 25 хувьд хүрснийг албаны эх сурвалж хэллээ

Тухайлбал, 2011 онд Монголын эдийн засаг 17.3 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтөөрөө Монгол Улс тив дэлхийд тэргүүлэх үед иргэн Батын өрхийн дундаж орлого 2011 онд 120 мянган төгрөгөөр өсчээ. Гэтэл дараа

жил буюу 2012 онд бараг хоёр дахин өсөж, 800 мянган төгрөг давж байжээ. Эдийн засгийн тоон өсөлт Багад бодитоор наалдахад ийнхүү хугацаа хэрэгтэй болдог байна. Харин тогтвортой бус, уул шиг өсгөж, уруудсан эдийн засаг ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, цалин хөлсийг нэмэгдүүлдэггүй байна.

Бас эдийн засгийн өсөлт нь манайд зарим талаар сөрөг нөлөөтэйг Дэлхийн банкнаас анхааруулсан. Уг нь өсөлт нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн орлого өсгөснөөр ядуурлыг бууруулах ёстой. Гэтэл манайд эдийн засгийн өсөлт нь инфляц хөөрөгдөх шалтгаан болж, улмаар өрхийн худалдан авах чадварыг бууруулж, ядуурал багасахад саад болдог гэсэн судалгааны дүн гарчээ.

Цаашлаад эдийн засгийн энэ өсөлтийг үр ашигтай зарцуулалгүй, хавтгайрсан халамж хэлбэрээр тараасан нь хөдөлмөр эрхлэлтийг боомилж, төр өөрөө ажилгүйдэл, ядуурал руу ард иргэдээ түлхдэг. Үүнийг ч сүүлийн 6-7 жилд манай улсад өрнөсөн улс төрийн амлалт, хавтгайрсан халамж бэлээхэн батална. Мөн баялгийн тэгш бус байдлыг дэвэргэж, нийгмийн тэгш бус байдалд хүргэдэг. Аль ч нийгмийн хөгжлийн зүтгүүр болдог дундаж давхарга хүн амынхаа 60-70, бүр 80 хувийг эзэлдэг. Гэтэл дундаж давхарга нимгэрсээр өдгөө 30 хувьд хүрээд байгаа.

СЭЗИС-ийн багш, доктор, дэд профессор Ж.Дэлгэрсайхан “Ядуурлын үр дагавар маш ноцтой. Хүн хэрэгцээгээ хангаж чадахгүйд хүрэхээс гадна ядуурал нийгмийн сэтгэлгээг доройтолд хүргэдэг. Эрүүл мэнд, гэмт хэрэг зэрэг нийгмийн үзүүлэлтүүдийг доош чангааж, нийгмийн дотор харилцан адилагүй түвшнүүд бий болгон, үл ойлголцол төрүүлдэг” гэв. Өөрөөр хэлбэл, ажилгүйдэл, ядуурал нь зөвхөн эдийн засгийн гэлтгүй нийгмийн суурь эмгэг болж таарч байна. Эдүгээ Монголын нийгэмд аюулын харанга дэгдээж, айдаст автуулж буй хүүхэд хамгаалал, агаарын бохирдол, боловсролын хүргээмж гээд бүх асуудлын цаана ядуурал нуугдаж байна. Ядуурал дагаж монгол хүний үнэлэмж унаж, тэр бүү хэл эрүүл мэндийн доройтолд орж, өвчин эмнэгт нэрвэгдэж байна. Тиймээс Монгол Улсад хуримтлагдсан бүх асуудал, зовлонгийн үндэс болох ядуурал, ажилгүйдлийг бууруулахад төрийн бодлогыг чиглүүлэх цаг нэгэнт болжээ. [ЗГМ]

## С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



©2018. SOTB & ZGM



## Нийгэм

# Дэд төвийг тойруулан 10 мянган айлын орон сууц барина



Б.Батдорж / ЗГМ©

## Дэд төвүүдийн ажлыг ирэх жил бүрэн дуусгахаар төлөвлөжээ

Б.Энхжин  
ЗГМ

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийслэл хот зургаан дэд төвтэй байхаар тусгасан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төв байгуулах ажил эхэлж, нийт 318 га газарт төлөвлөлт хийгээд байгаа юм. Өчигдөр БХБ-ын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга С.Батболд нар дэд бүтцийн төвүүдэд ажиллалаа.

Одоогоор дээрх хоёр дэд төвд 50 айлын тус суурьших орон сууц тус бүр нэгийг бариад байна. Мөн Баянхошуу дэд төвд 2.3 км урттай үерийн хамгаалалтын суваг

хайсны угсралт хийж дуусчээ. Цаашид энд 7.42 км автозам, 1000 шоо метр хүчин чадалтай усан сан, доод насос станц, өргөлтийн насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой тавих юм байна.

Энэ үеэр Х.Баделхан сайд “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, төвлөрлийг задлахаар хийж байгаа хамгийн том төсөл энэ юм. Хот хөгжүүлэхэд хамгийн гол ажил нь инженерийн дэд бүтэц. Эдгээр дэд төвд дулаан, цахилгаан, үерийн хамгаалалтын ажил дэс дараатай хийж байна. Төслийн хүрээнд 10 мянган айлын орон сууц барина. Инженерийн дэд бүтэц байгуулсны дараа орон сууц барих асуудал шийдэгдэнэ. Цаашдаа энд шинэ төв, шинэ хот бий болно” гэлээ.

Төслийн хүрээнд 240 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, Бизнес инкубатор төв, МСҮТ-ийн барилга баригдаж байна. Баянхошуу дэд төвд цэцэрлэгийн насны 4700 гаруй хүүхэд байгаагаас 2740 нь цэцэрлэгт

хамрагддаг аж. Харин тус цэцэрлэг ашиглалтад орсноор сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 63 хувь болж нэмэгдэх юм. Цэцэрлэгийг ирэх сарын 15-нд, МСҮТ-ийн барилгыг ирэх сарын 30-нд хүлээлгэн өгөхөөр төлөвлөжээ.

Нийслэлийн Засаг дарга С.Батболд “Нийслэл хот Бага тойруу гэсэн ганц төвтэй. Түүнийг дагасан замын түгжрэл, төвлөрөл гээд олон бэрхшээл бий. Гэтэл нийслэлд 1.4 сая орчим иргэн оршин сууж байна. Бид Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Баянхошуу, Сэлбэ дэд төвийг байгуулж байна. Төслийн гол онцлог нь нийгмийн асуудлыг маш сайн харгалзаж үзсэн. Нөлөөлд өртсөн айлуудыг шинээр байртай болтол орон сууцаар хангахад анхаарсан. Энэ жил төслийн 50 хувийг гүйцэтгэн, ирэх жил бүрэн дуусгахаар ажиллаж байна. Ингэснээр таван хорооны иргэдийг цахилгаан, дулаан, цэвэр бохир усны системтэй

Баянхошуу дэд төвийг түшиглэн 240 хүүхдийн цэцэрлэг, МСҮТ төв ашиглалтад орно

холбоно. Энд өндөр орон сууц, худалдааны байгууллагууд, сургууль, цэцэрлэг гээд олон бүтээн байгуулалт босох учиртай. Орлогод нийцсэн орон сууцны ихэнхийг дэд төвүүдэд түшиглэн барих юм. Ингэснээр өндөр өртгөөр ирсэн дэд бүтцийг ашиглах боломж бүрдэнэ” гэлээ.

Сэлбэ дэд төвд хийж буй бүтээн байгуулалтын үр дүнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийг дамнан 158 га талбайд оршин сууж буй иргэдийг дулааны эрчим хүчээр найдвартай хангах аж. Дулааны станц бүрэн ашиглалтад орохоор айл өрхүүд шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ. Ингэснээр хотын агаарын бохирдлын 80 гаруй хувийг үүсгэж буй гэр хорооллын халаалтын болон айл өрхийн зуухны түүхийн нүүрсний хэрэглээг жилд 15 мянган тонноор бууруулах тооцоо бий. Мөн 3700 өрхийн зуух, 10 гаруй аж ахуйн нэгжийн уурын зуухыг хэрэглээнээс халах тооцоо гаргажээ. [ЗГМ]

## ОРОН НУТАГ

### » ЗАВХАН

Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад аймгийн иргэдийн мөнгөн хадгаламж 15 тэрбум төгрөгөөр өссөнийг талаар Монголбанкны Завхан салбараас мэдээлэв. Наймдугаар сарын мэдээллээс үзэхэд гүйлгээнд 8.1 тэрбум, иргэдийн мөнгөн хадгаламжинд 84.5 тэрбум төгрөг байна. Аймгийн хэмжээнд 82.9 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар өссөн дүн юм.

### » ӨМНӨГОВЬ

Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “Номадик Экспедишн” компанийн салбар “Говийн гурван тэмээ” ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аравдугаар сарын 4-нд Улаанбаатараас Даланзадгад чиглэлийн тусгай нислэгт иргэдийг үнэгүй зорчуулахаар болжээ. Энэ өдөр тусгай нислэгийн 50 суудлыг хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, жирэмсэн эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй болгосон байна.

### ОНЦЛОХ МЭДЭЭ

## МИАТ нойтон түрээсийн нислэгээ амжилттай гүйцэтгэлээ



Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн В-737-800 агаарын хөлгийн баг БНЧУ-ын Travel Service компанид нойтон түрээсийн гэрээт ажлаа амжилттай гүйцэтгээд, энэ сарын 24-нд эх орондоо газардлаа. “МИАТ” ТӨХК тус компанид агаарын хөлгөө сүүлийн дөрвөн жил дараалан түрээслүүлж байгаа бөгөөд энэ удаа Европын 50 гаруй чиглэлд нислэг үйлдсэн байна. “МИАТ” агаарын хөлгөө нойтон түрээсийн гэрээгээр түрээслүүлснээр санхүүгийн нэмэлт эх үүсвэр бий болгоод зогсохгүй, Европын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа нь манай улсын агаарын тээврийн салбарын нэр хүндийг олон улсад өргөсөн явдал болсныг мэргэжилтнүүд онцолж байна. Энэ талаар “МИАТ” компанийн Коммер эрхэлсэн дэд захирал Ш.Гантулга “Манай компани 2015 оноос хойш дөрвөн жилдээ агаарын хөлгөө нойтон түрээсээр түрээсэлж байна. Энэ удаа БНЧУ-ын Travel Service компанид таван сарын хугацаанд түрээсэлж, ямар нэгэн алдаа дутагдалгүй эх орондоо амжилттай газардаж байна. Өмнөх жил нь бид Атлантын далайг давж, Америк тивд онгоцоо нисгэж байсан” хэмээн яриу.

## [ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга  
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч  
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх  
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч  
Лхагважавын СУГАРМАА  
Утас: 99903574

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба

Эдитор Б.Энхжаргал  
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба

Эдитор Г.Баярсайхан  
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581  
99903578  
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,  
“Бло Скай таур” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар: 1024  
Утас: 70103131,  
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn  
ubinfo.mn  
Дугаарын удирдагч  
З.Цэлмэг



## Millennium Challenge Account (MCA) – Mongolia

Closing Date: 17.00 ULAT, October 1, 2018

### About MCA-Mongolia

The Government of Mongolia (“Government”) seeks qualified individuals to help organize, manage and lead a new special purpose entity to be known as the Millennium Challenge Account – Mongolia (“MCA-Mongolia”). The Government will shortly establish MCA-Mongolia in the form of a state-owned enterprise to oversee the implementation of the Mongolia Water Compact (the “Compact”), a major international development assistance program funded by the Millennium Challenge Corporation (“MCC”), a United States Government agency that provides grant assistance to help partner countries promote economic growth and reduce poverty.

The Compact aims to increase the long-term sustainable supply of water to Ulaanbaatar and stem the impact of an impending water crisis. The Compact will expand the supply of water to residential consumers and commercial and industrial users in Ulaanbaatar through:

- The construction of new groundwater wells downstream from Ulaanbaatar and introduction of a state-of-the-art water purification plant;
- The construction of a new freshwater recycling plant and pipelines to provide high-quality treated freshwater;
- Policy reforms, capacity building, and technical assistance to improve the long-term sustainability of Ulaanbaatar’s water supply.

MCA-Mongolia will oversee the implementation of these investments on behalf of the Government and in compliance with the guidelines and standards of MCC.

### THE ROLES

#### DEPUTY CHIEF EXECUTIVE OFFICER, PROGRAMS

Main Tasks: The Deputy Chief Executive Officer, Programs, is responsible for coordinating, managing and leading the work of the Program Division, which will implement within tight timelines and fixed budget three complex, interrelated investment activities in water supply, wastewater recycling and water sector sustainability. The Deputy CEO assists in inspiring and motivating the program staff of MCA-Mongolia; setting operating procedures and practices; ensuring quality, cost and timeliness; integrating cross-cutting inputs related to environmental and social performance, gender and social integration, and monitoring and evaluation; ensuring compliance with MCC standards, policies and guidelines as well as with local requirements. The Deputy CEO manages six director-level staff in a division of up to 18 staff and will help manage a large number of services and works contractors.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7695>

#### DIRECTOR, ADMINISTRATION

Main Tasks: The Director, Administration, is responsible for developing and implementing administrative policies and procedures and managing the daily operations of MCA-Mongolia, including office services, facilities management, transportation and logistics, information technology, and staffing and human resources. The Director, Administration, reports directly to the Chief Executive Officer (CEO) and supervises three

managers in a division of twelve (12) staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7705>

#### DIRECTOR, PROCUREMENT

Main Tasks: The Director, Procurement, is responsible for managing and oversight of all of MCA-Mongolia’s procurement operations to ensure the successful procurement of all necessary goods, works and services efficiently, with integrity, and within tight timelines. The Director, Procurement, reports to the Chief Executive Officer (CEO) and manages two (2) dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7698>

#### DIRECTOR, FINANCE

Main Tasks: The Director, Finance, is responsible for the management and oversight of all of MCA-Mongolia’s budgeting, financial planning, financial management and financial reporting to ensure discipline and provide efficiency, effectiveness, transparency and accountability in the expenditure of MCA-Mongolia’s funds. The Director, Finance reports to the Chief Executive Officer (CEO) and manages two dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7697>

#### MANAGER, HUMAN RESOURCES

Main Tasks: The Manager, Human Resources is responsible for the payroll, benefits and entitlements, performance management, personnel files, and the human resources information system (HRIS) of MCA-Mongolia. The Manager, Human Resources, reports to the Director, Administration, and supervises one dedicated staff member.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7708>

An equitable selection process will be conducted whereby candidate selection will be based on merit. All interested parties with relevant experience are encouraged to apply. Qualified applicants will receive consideration for employment without regard to race, ethnicity, religion, sex, national origin, or disability. No fees will be paid to MCA-Mongolia or any of its agents at any stage of the recruitment process (application, interview, processing, training fees or other).

**SRI Executive** ([www.sri-executive.com](http://www.sri-executive.com)) is assisting the Government of Mongolia in its search for exceptional candidates for MCA-Mongolia. SRI Executive operates under a contract provided by MCC. SRI Executive is supported by our local partner Specialized Career Consulting (SCC) in this recruitment initiative.





## Иргэд хүнс авахдаа чанараас илүү үнийг нь харж сонгодог хэвээр

Манай улсад жилд дунджаар 400-500 хүн хоол хүнсээс шалтгаалсан нянгийн гаралтай халдварт өвчнөөр өвчилдөг гэсэн УСХ-ны мэдээлэл байна. Тиймээс бараг л амандаа орж буй хоол болгонд санаа зовохоос аргагүй.

ЭМЯ, НЭМҮТ-өөс явуулсан хүн амын хүнс, тэжээлийн судалгаагаар нийт өрхийн 65 хувьд нь хүнсний баталгаат байдал буюу чанар, хүртээмж алдагдсан гэсэн дүн гарсан. Задалж харвал, 14 хувь нь бага, 28 хувь нь дунд зэрэг, 23 хувьд нь ноцтой алдагджээ. Өөрөөр хэлбэл, дөрвөн өрхийн нэг нь чанартай, хангалттай хоол хүнс огт хэрэглэж чадахгүй байна. Ялангуяа орлого багатай өрхүүдэд үнийн зөрүүнээс шалтгаалж хамгийн хямд, чанаргүй хүнсээр бор өдрүүдийг өнгөрөөж буй. Дотоодоосоо хамгийн сайн хангаж буй мах, төмс гэхэд импортын ижил бүтээгдэхүүнээс өндөр үнэтэй. Тиймээс монголчуудыг эрүүл хүнсээр хангана гэсэн төрийн бодлого энд үнэтэй “мөргөлдөөд” бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа. “Эрүүл амьдарья гэвэл дотоодын хүнс хэрэглэх нь илүү найдвартай. Гаднаас олон хоног тэвээрлэж авчирсан, чанарын баталгаагүй хүнс авахгүй байя гэхээр дотоодынх нь илүү үнэтэй байна. Чанар гэхээс илүү мөнгөндөө тааруулаад хүнсээ авдаг” гэж 33 настай Б.Батчимэг хэллээ. Нэг кг хонины мах гэхэд жилийн ихэнх үед БНХАУ-аас импортолсон чанар муутай тахианы махнаас үнэтэй. Монгол сортын төмсийг импортынхоос бараг 50 хувиар илүү үнээр зардаг. Үүнийг хэлэхэд Монголд дотооддоо




Б.Батдорж / ЗГМӨ

Монголчууд 70 орчим сая малтай ч баталгаатай, эрүүл мах хэрэглэж чадахгүй байна.

Хэчнээн бага хэмжээтэй, хоолны чухал орц биш байсан ч хор хөнөөл нь их. Тухайлбал, арав орчим жилийн өмнө монгол үсү нэртэй цагаан нунтаг амтлагч нийтийн хэрэглээ байсан. Гэвч ходоодны шарх үүсгэдэг нь багдалдсан учраас манай улс импортлохыг хориглосон. Магадгүй энэ амтлагчаас болоод өнөөдөр ходоодны хорт хавдрын тохиолдол ийм өндөр болсныг үгүйсгэх аргагүй. Дээр нь түргэн хоол, хийжүүлсэн ундаа, чипс болон транс тостой гээд дэлхий нийтээр эрүүл мэндэд хортой нь нотлогдсон хүнс манайд харин ч давуу эрхтэй зарагддаг. Энэ мэтээр хүнсний салбартай холбоотой олон бодлого, шийдэл хоосон байна. Засгийн газраас 2009-2016 онд “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж дууссан. Харин өнөөдөр яриа төдий

# Дөрвөн өрх тутмын нэг нь огт баталгаагүй хүнс хэрэглэдэг



хамгийн сайн үйлдвэрлэж, үнэ болон борлуулалтаараа импортыг бут цохиж байгаа салбар архины үйлдвэрлэл л байна. Гэвч ганц “босоо” байгаа энэ салбар монголчуудын эрүүл мэнд, эдийн засгийг доройтуулна уу гэхээс өөд татахгүй. Гэхдээ монголчууд баталгаагүй хүнс хэрэглэж байгаа нь зөвхөн төрийн бодлого сул, хяналт дутмагаас шалтгаалдаггүй. Үйлдвэрлэгчид, худалдаачид эрүүл ахуй, халдгалалтын горим мөрддөггүй, түүнд нь хатуу хяналт тавьж чаддаггүйгээс дотоодын хүнсээ 100 хувь эрүүл гэж хэлж чадахгүй. Шуудай төмс худалдаж авлаа гэхэд дунд нь дор хаяж нэг кг хятад, эсвэл муудсан төмс хийсэн байх нь энгийн л үзэгдэл. Дээрээс

нь агаар, хөрсний бохирдол “хачир” болж, утаатай, хүнд металлтай хоолоор гэдсээ тэжээсээр.

## Дотоодын хэрэгцээгээ хамгийн сайн хангаж буй нь архины салбар

Харамсалтай нь, худалдаанд байгаа дийлэнх хүнс эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй химийн бодис агуулаагүй гэсэн баталгаа алга.

байгаагаас яг хүнсний аюулгүй байдлыг онилсон дорвитой бодлого алга гэхэд хилсдэхгүй. Хүнсний аюулгүй байдал бол нэг өдөр шийдэгдэх асуудал биш, маш олон зангилаатай. Өөрөө ч нийгмийн олон асуудлын гол хэлхээ болдог. Тиймээс эхний ээлжинд импортоор орж ирж буй иргэдийн эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүнүүдийн хяналтыг чангатгах ёстой гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна. Хүнсний импортын ихэнх хувийг эзэлдэг БНХАУ-ын өндөр албан тушаалтан тус улсын бараа, бүтээгдэхүүний чанарт баталгаа өгч чадахгүй гэдгийг дэлхий нийтэд зарлачихсан энэ үед бидэнд эрүүл мэнд, амь насаа хамгаалах “хана хэрэм” хэрэгтэй байна. [ЗГМ]

## ЗГМ: НЭГ АСУУЛТ

### Монголд хүнсний аюулгүй, баталгаат байдал алдагдсан уу?



Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны иргэн С.Нармандах

Манай гэр бүл аль болох мах, гурилаа л идэхийг хичээдэг. Бусдынх нь түүхий эдийг ихэнхдээ Хятадаас оруулж ирж байна. Ер нь хамгийн хямд, мууг нь л оруулж ирж идэж байна шүү дээ. Сүүлдээ бүр хамгийн эрүүл, экологийн гэдэг махаа ч идэхэд хэцүү болчихоод байна. Жижиглэнгээр ямар мах зарж байгаа нь ч мэдэгдэхгүй учраас гулуузаар нь авдаг. Таньдаг малчны гарнаас авахгүй л бол ямар ч баталгаа алга. Зарим маханд тариа тарьснаас бэрүү үүссэн байдаг. Ийм махыг яаж идэх юм бэ.



Баянбол дүүргийн 3 дугаар хорооны иргэн О.Мягмаржаргал

-Хүнсний аюулгүй байдалд итгэлгүй байдаг. Төмс, хүнсний ногоо гэхэд химийн бордоотой гэсэн мэдээлэл зөндөө гарч л байна. Миний хувьд нутгаасаа хүнсний ногоогоо авчирч хэрэглэдэг. Гэхдээ монгол тариаланчид ч ногоогоо химийн бордоо, бодисоор ургуулдаг юм билээ. Ногоо тарихдаа стандартгаа барьдаггүй, өөрсдийнхөө дураар хэрэглэдэг. Уг нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжээд монгол ногоогоо хэрэглэмээр байна. Даанч 100 хувь итгэх арга алга.



Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны иргэн Г.Цэнд

Монголд хүнсний аюулгүй байдал алдагдсан гэдэг шиг үндэн юм байхгүй. Намайг хүүхэд байхад монголчууд үнэхээр цэвэр, тансаг бүтээгдэхүүн хэрэглэдэг байж. Зах зээлийн системд шилжсэнээс хойш хүнсний аюулгүй байдал, баталгаа их хэмжээгээр алдагдлаа. Гаднаас чанар муутай хүнсний бүтээгдэхүүн их орж ирж байна. Бас химийн бодисгүй хүнс гэж алга. Бизнес хийх гэж дуртай болгоноо оруулж ирж зарж байгаад хяналт тавих хэрэгтэй.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 09 дүгээр сарын 25

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** “Ногоон булан ахмадын амралт, сувилал ОНӨААТҮГ-ын заал шинэчлэн барих ажил”  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** ЧДХААА А18/051

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Ногоон булан ахмадын амралт, сувилал ОНӨААТҮГ-ын заал шинэчлэн барих ажил”**-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна. Үнийн саналыг **2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутас өмнө** Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж -16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 5 дугаар давхар, 511 тоот өрөө гэх хаягаар ирүүлнэ. Тендерийн баримт бичигийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **100 000 /нэг зуун мянга/** төгрөгөөр худалдаж авна. Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны **Төрийн сан банкин дахь 100200751009 тоот дансанд** тушаана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:  
**Сүүлийн 2 жил /2016, 2017 он/-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ:** 210 000 000 /хоёр зуун арван сая / төгрөгөөс багагүй байна.  
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил /2016, 2017/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 210 000 000 /хоёр зуун арван сая / төгрөгөөс багагүй байна.  
**Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлага:** Сүүлийн 2 жилийн аль нэгэнд ядаж нэг удаа 210 000 000 /хоёр зуун арван сая / төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.  
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 90 000 000 /ерэн сая/ төгрөгөөс багагүй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2016, 2017 он  
Тендерийн хамт 4 500 000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.  
**Уг гэрээг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх:** “Тийм” Шаардлагатай тусгай зөвшөөрөл:

**Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.**  
**1.2.1** 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)  
**1.2.4** Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам шүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл  
**1.2.5** Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /10кВ хүртэл/ Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, төмөр замын холбоо, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

**Эсхүл шинэ журмын:**  
**ЗТ-2.1** Архитекур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл /БЗБТ, АГТ, ҮЗБТ/  
**ЗТ-3.4** Ус хангамж, ариутгах татуургын гол /магистраль/ шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг,  
**ЗТ-3.5** Дулааны гол /магистраль/ шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг,  
**ЗТ-3.6** Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн ажлын зураг,

**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.**  
**2.1.1** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт  
**2.1.2** Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцийн барилгын угсралт, өргөтгөл шинэчлэлтийн ажил /1-5 хүртэл давхар/  
**2.2.1** Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт  
**2.2.2** Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

**Эсхүл шинэ журмын:**  
**БА-2.1** Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажил,  
**БА-6.1** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,  
**БА-6.1** Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,  
**БА-6.1** Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,  
Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 11 цаг 30 минутад нээнэ. Гадаадын этгээд: **Оролцох эрхгүй**  
Дотоодын давуу эрхийн зөрүү: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 5 дугаар давхар, 511 тоот өрөө, Утас : 70110769

## “ДИ БИ ЭМ ЛИЗИНГ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм Лизинг” ХХК нь 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн түрээс буюу лизингийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

“Ди Би Эм Лизинг” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар компанийн засаглалын хэлбэрээ өөрчилж, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн тул Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХХХ-26 тоот шийдвэрийг тус тус үндэслэн “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гурван гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

### СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТОО -3 ТАВИГДАХ ШААРДАГА:

1. Зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;
2. Банк, санхүү, эрх зүй, инженер, эдийн засгийн дээд боловсролтой, тухайн салбарт удирдах албан тушаалтнаар таваас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;
3. Ял шийтгэлгүй байх;
4. Төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх, сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал хашж байгаагүй байх;
5. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;
6. Монгол Улсын Хөгжлийн банкнаас бусад банкны салбарын байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх;
7. Зөрчлийн улмаас банк, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан байгаагүй байх;
8. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.
9. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх.
10. Компанийн тухай хуулийн 79.1-т заасан шаардлагууд.

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. Төрийн албан хаагчийн анкет, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын

- урьдчилсан мэдүүлэг, гурван үеийн намтар;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Цээж зураг 4х6 см хэмжээтэй 2 хувь;
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
- Оршин суугаа газрын тодорхойлолт;
- Иргэний ял шийтгэлтэй эсэх талаарх лавлагаа;
- Монголбанкнаас “Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээн хугацаа хэтэрсэн аливаа өргүй” тухай тодорхойлолт;
- Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалсан эсэх тухай” шүүхийн лавлагаа;
- “Зөрчлийн улмаас банкны тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх талаарх” Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолт.

### СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, “EAST PLAZA” 39-р байр 5 давхар, утас: 77307070, “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Түр хорооны Нарийн бичгийн дарга Б.Энхтүшиг / Утас: 80005060 Цахим хаяг: [enkhutushig.b@dbmleasing.mn](mailto:enkhutushig.b@dbmleasing.mn) /

### МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:

Сонгон шалгаруулалтад оролцох иргэний материалыг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна. Материалыг битүүмжлэн ирүүлэх шаардлагатай.

### АНХААРАХ ЗҮЙЛС:

1. Материалыг битүүмжилсэн байх ба дугтуйн гадна талд сонгон шалгаруулалтад оролцогч иргэний нэр, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаарыг гаргацтай бичнэ.
2. Материалыг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй.
3. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
4. Материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
5. Сонгон шалгаруулалтын шаардлага хангасан иргэнтэй Нэр дэвшүүлэх хорооноос холбоо барина.



# Өдрийн хэмнэл

## ТВ ХӨТӨЛБӨР



- 06.00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр
- 10.20** “Brain wave” англи хэлний уралдаант нэвтрүүлэг
- 14.00** “Ухаарч амьдрах хорвоо” ОАУСК 15,16 дугаар анги
- 18.00** Прокурорын цаг
- 20.00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр /шууд/
- 22.15** “Мэргэжилтэн” Монголын ОАУСК 8 дугаар анги

## Bloomberg TV Mongolia

- 07.00** “Өсөлтийн замд” нэвтрүүлэг
- 09.00** “Бизнесийн хэмнэл” хөтөлбөр
- 14.00** “Америкийг бүтээсэн автомашинууд” нэвтрүүлэг
- 17.00** “Bloomberg Surveillance”
- 20.00** “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг
- 22.30** “Ногоон хот” нэвтрүүлэг

## БОЛОВСРОЛ HD

- 07.05** “Ай Күү” 45, 46 дугаар анги
- 10.05** “Яг чам шиг охин” ОАК 39, 40 дүгээр анги
- 12.55** “Кино миний амьдрал” нэвтрүүлэг
- 15.50** “Аугаа уран зургууд” нэвтрүүлэг
- 18.05** “Тобот” 1-21, 22 дугаар анги

- 22.00** “Эж” ОАК 20 дугаар анги



- 06.30** “Тог тог тог” /season-6/ 26-1 дүгээр хэсэг
- 10.30** “Эж” СОАК 13-р анги
- 12.30** “The Voice of Mongolia” /season-1/ 11 дүгээр хэсэг
- 17.30** “Мөрдөгч хүүхдүүд” ОАК /season-1/ 15,16 дугаар хэсэг
- 20.00** “Гранд зочид буудал” Испани ОАК 8 дугаар анги
- 00.30** “Хар жагсаалт” ОАК /season-3/ 17 дугаар анги

## ЗУРХАЙ



**Билгийн тооллын 16**  
Намрын дунд цагаагчин тахиа сарын долоон улаан мэнгэтэй цагаагчин тахиа өдөр.  
**Үс засуулбал:** Өвчин ирнэ  
**Наран ургах, шингэх:** 06.45-18.40  
**Барилдлага:** Рашаан  
**Шүтэн барилдлага:** Авахуй  
**Суудал:** Уул

**Аргын тооллын есдүгээр сарын 26, Буд гараг. Билгийн тооллын 16, Дэлгэрүүлэгч одтой, цагаагчин тахиа өдөр.**  
Өдрийн наран 06.45 цагт мандаж, 18.40 цагт жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүлжээ. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, гарагийг тахиж, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар явара одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



**“Чөлөөт хос” инээдмийн жүжиг**  
Хэзээ: 2018.09.26-ны 19.00 цагт  
Хаана: УДЭТ  
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



**Grandeur модерн балет**  
Хаана: УДБЭТ  
Хэзээ: 2019.09.28-ны 19.00 цагт  
Тасалбарын үнэ: ₮30-40 мянга



**“Гоё кап” волейболын залуучуудын УАШТ**  
Хэзээ: 2018.09.29-10.03  
Хаана: Спортын төв ордон  
Тасалбарын үнэ: ₮ 3-10 мянга

## ОНЦЛОХ ҮЗВЭР

# “Нар” хүндэтгэлийн тоглолт



Монголын анхны метал рок хөгжмийн хамтлаг болох “Хурд” 25 жилийн ойдоо зориулсан “Нар” тоглолтоо хийх гэж байна. UB Palace-ийн их танхимд ирэх сарын 5-6-нд болох тоглолтод тус хамтлагийн гишүүн болсон Voice шоуны шилдэг оролцогч

А.Болормаа оролцох аж. Тасалбарын үнэ 25-50 мянган төгрөг. Эргэн сануулахад “Хурд” хамтлагийг анх 1987 онд Төмөр замын вагон депогийн ажилчин хэсэг залуус анх байгуулж уран бүтээлээ туурвиж эхэлсэн юм. Улмаар 1991 оны ардчилсан хувьсгал

гарч уг хамтлагийн нэгдүгээр бүрэлдэхүүн тарсан байна. Харин тус бүрэлдэхүүнд тоглож байсан бөмбөрчин Д.Ганбаяр хамтлагийнхаа нэрийг авч үлдэн, 1993 оноос метал рок хөгжмийн төрлөөр уран бүтээлээ туурвисаар өнөөдрийг хүрчээ. [311]



**“Сэтгэл догдлуулсан орой” тоглолт**  
Хаана: Corporate Convention Centre  
Хэзээ: 2018.09.28-29-ний 19.00 цагт  
Тасалбарын үнэ: ₮ 40-60 мянга



**“Тамгагүй төр” түүхэн жүжиг**  
Хаана: УДЭТ  
Хэзээ: 2018.10.6, 7-ны 18.00 цагт  
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



**“Би эндээс явахгүй” драмын жүжиг**  
Хэзээ: 2018.10.12-14  
Хаана: УДЭТ  
Тасалбарын үнэ: ₮ 10-25 мянга

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

|    |   |    |    |  |    |
|----|---|----|----|--|----|
| 1  | 2 | 3  | 4  |  |    |
|    |   | 5  |    |  |    |
| 6  |   |    |    |  |    |
| 7  |   | 8  | 9  |  | 10 |
|    |   | 11 |    |  |    |
| 12 |   |    | 13 |  |    |

### ХӨНДЛӨНГӨӨР:

1. Эмэгчин гахай
3. Монгол үндэсний хөгжим
6. Туршлагаас авсан мэдлэг
7. Зэрлэг жимс

9. Шатрын тавил
11. Газрыг хэмжих нэгж
12. Халх голын болон чөлөөлөх дайнд оролцсон Монголын армийн нэр (товчилсон нэр)
13. Үйлийн хэрэгсэл

### Өмнөх дугаарын хариу / 09.25


|   |   |   |   |   |   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Т | А | В | А | Н | Э | Р | Д | Э | Н | Э |
| А |   | И | Э |   | А |   | Л |   | Н |   |
| Р | Е | П | И | Н |   | Х | А | С | А | Х |
| В |   |   | Н |   |   | С |   |   |   | Б |
| А | Г | Л | У | У |   | М | А | Н | А | А |
| Г |   | Е |   | Я |   | А |   | О |   | Я |
| А | Р | И | У | Н | Б | А | А | Т | А | Р |

## БОСООГООР:

2. Өнгөт металл
4. Архангай аймгийн томоохон гол
5. Ноёны хүү
7. Мөнгөн гүйлгээний машин (товчилсон нэр)
8. Суварга
9. Гэрийн тооныг бүтээх зүйл
10. Ачийн хүүхэд

## ЦАГ АГААР

| УЛААНБААТАР | ИХ.26                    | ИХ.27                  | ИХ.28                   | ИХ.29                 | ИХ.30                 |
|-------------|--------------------------|------------------------|-------------------------|-----------------------|-----------------------|
|             | 19° 10 м/с<br>8° 6 м/с   | 5° 13 м/с<br>3° 10 м/с | 2° 12 м/с<br>-2° 10 м/с | 6° 8 м/с<br>-2° 8 м/с | 8° 6 м/с<br>-2° 5 м/с |
|             | Бага зэргийн хур тунадас | Цас                    | Бага зэргийн цас        | Ялимгүй цас           | Үрлшнээ               |



## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2018 оны компанийн санхүүгийн тайландаа олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул сонирхсон эрх бүхий этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь: “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 14-16 зүйлийн холбогдох шаардлагыг хангасан байхаас гадна уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга.
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
- Ижил төстэй ажлын туршлага дэлгэрэнгүй мэдээлэл.
- Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт./сүүлийн 1 жил, 2017 он/
- Монгол улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж төлбөрөө төлсөн эсэхийг нотлох татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг авч болох бөгөөд мэдүүлгээ 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 17 цаг 30 минутын дотор доорх хаягаар ирүүлнэ үү.

**“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК,**  
**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 5-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, 10Б байр, Бизнес Тауэр, 20 давхар**  
**Утас: 7577-0002**

## ЗГМ: СҮДОКУ

|   |   |   |   |   |   |   |  |  |  |   |
|---|---|---|---|---|---|---|--|--|--|---|
|   |   |   | 4 | 2 | 7 |   |  |  |  |   |
| 2 | 9 |   |   |   |   |   |  |  |  | 1 |
|   |   | 4 |   | 3 | 9 |   |  |  |  |   |
|   |   |   | 6 |   |   |   |  |  |  | 5 |
|   | 2 |   | 9 | 1 |   |   |  |  |  |   |
| 3 | 1 |   | 7 |   |   |   |  |  |  | 2 |
|   |   |   |   |   | 8 | 5 |  |  |  |   |
| 4 | 6 | 7 |   |   |   |   |  |  |  |   |
|   |   |   | 6 | 2 |   |   |  |  |  |   |

|   |   |   |   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 5 | 8 | 4 | 7 | 3 | 6 | 9 | 1 |
| 3 | 4 | 1 | 8 | 6 | 9 | 2 | 7 | 5 |
| 7 | 6 | 9 | 1 | 2 | 5 | 8 | 3 | 4 |
| 6 | 9 | 7 | 5 | 8 | 1 | 3 | 4 | 2 |
| 5 | 2 | 3 | 7 | 9 | 4 | 1 | 8 | 6 |
| 1 | 8 | 4 | 6 | 3 | 2 | 9 | 5 | 7 |
| 9 | 7 | 5 | 3 | 1 | 6 | 4 | 2 | 8 |
| 8 | 1 | 2 | 9 | 4 | 7 | 5 | 6 | 3 |
| 4 | 3 | 6 | 2 | 5 | 8 | 7 | 1 | 9 |



| УБ-МОСКВА    | 13.50 | 14.28 |
|--------------|-------|-------|
| МОСКВА -УБ   | 21.35 | 07.30 |
| УБ-ЭРХҮҮ     | 21.10 | 02.40 |
| ЭРХҮҮ-УБ     | 15.35 | 06.20 |
| УБ-СҮХБААТАР | 21.15 | 05.12 |
| СҮХБААТАР-УБ | 20.55 | 05.03 |



| УБ-БЭЭЖИН  | 00:00 | 00:40 |
|------------|-------|-------|
| БЭЭЖИН-УБ  | 01:40 | 04:10 |
| УБ-ХОНКОНГ | 06:25 | 10:55 |
| ХОНКОНГ-УБ | 12:05 | 16:45 |
| УБ-СӨҮЛ    | 08:40 | 12:50 |
| СӨҮЛ-УБ    | 14:20 | 17:00 |
| УБ-ТОКИО   | 07:45 | 13:40 |
| ТОКИО-УБ   | 14:40 | 19:15 |

## ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

“Засгийн газрын мэдээ” сонин 2018.09.21-ний 186 дугаарт нийтлэгдсэн “Дахин нэг хүүхдийн амины үнээр тахилга хийж нааджээ” нийтлэлд унаач хүүхдийн аюулгүй байдлын талаар ярьсан эх сурвалж болох ГБХЗХГ-ын Хуулийн албаны дарга А.Энхбаатар гэснийг Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг дарга Б.Амараа хэмээн залруулан уншина уу.

» [INFO@ZASAG.CO](mailto:INFO@ZASAG.CO)

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



# ZGM DAILY

## President Battulga meets his Azerbaijani counterpart

Azerbaijani President notes the two countries can cooperate on oil refinery.

## Independent Authority Against Corruption holds press conference

IAAC announces to confine former CEO of EMC as a suspect to Just Group case.

## Mining Minister pays a working visit to the Russian Federation

The delegation is expected to meet with the CEO of Rosneft.

## Top 20 Index grows 0.24 percent, to 19,912.97 points

Market cap stands at MNT 2.32 trillion.

### ZGM: HIGHLIGHTS

#### POLITICS

Prime Minister of Mongolia Khurelsukh Ukhnaa attends the high-level meeting on the Global Call to Action on the World Drug Problem, which convened during the 73rd session of the United Nations' General Assembly. On the sidelines, PM Khurelsukh Ukhnaa met with the President of the United States Donald Trump and expressed Mongolia's support towards his initiative to combat the world drug problem.

Delegation led by the Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren is paying a working visit to the Russian Federation and Port of Taman. The delegation is expected to meet with Igor Ivanovich Sechin, CEO of Rosneft and the de facto deputy of Vladimir Putin.

Governor of the Bank of Mongolia Bayartsaikhan Nadmid submits the draft of 2019 Monetary Policy Guidelines to the Parliament Speaker Enkhbold Miyegombo.

#### ECONOMY

Asian Development Bank (ADB) approves USD 25 million loan to help the Government of Mongolia improve its tax administration and public investment management using information and communication technology. According to ADB, the project will streamline processes for tax administration and public investment in line with international good practice.

In the first eight months of this year, mining sector accounted for 26 percent of total budget revenue.

Top 20 Index grows 0.24 percent, to 19,912.97 points. MSE A Index declines 0.85 percent, to 9,399.16 points. MSE B Index falls 1.04 percent, to 8,818.43 points. Market cap stands at MNT 2.32 trillion.

#### SOCIETY

Authorities of Uvurkhangai aimag and Takikawa city of Japan sign a memorandum to cooperate on construction and health.

Chief of Staff of Office of the President Enkhbold Zandaakhuu attends the launch of the Silk Way rally which took place in Xi'an, China. According to Mr. Enkhbold, the Silk Way Rally will be held under the auspices of the President of Mongolia in 2019.

Women's Diplomatic Club at the Ministry of Foreign Affairs organized the 18th International Charity Fair.

# Potential cooperation on oil refinery discussed with Azerbaijan

## President Battulga Khaltmaa pays a working visit to Azerbaijan


Tugsbilig.B  
@tugsbiligZGM

President of Mongolia Battulga Khaltmaa is paying a working visit to the Republic of Azerbaijan. President Battulga held a bilateral meeting with his Azerbaijani counterpart Ilham Aliyev in tete-a-tete (face-to-face) and extended formats. The bilateral meeting took place in the Zagulba Palace, Baku, in a business-like and friendly atmosphere.

At the beginning of the meeting, President Ilham Aliyev welcomed President Battulga to Azerbaijan, expressing his appreciation of the latter's working visit.

During the meeting, President Battulga recalled an interesting detail in bilateral relations wherein the Baku Oil Refinery established a small plant in Zuunbayan, Mongolia, on December 5, 1951, and ran the plant until 1969 with Azerbaijani experts coming to Mongolia to work at the plant. President Ilham Aliyev listened to the story attentively and noted that it was possible for the two countries to cooperate in this sector, given the past experience.

The heads of state of Mongolia and Azerbaijan agreed to jointly



enter foreign markets via Mongolian territory, actively participate in regional development, and explore opportunities to cooperate on logistical assistance in exporting Mongolian-made products to the world market.

After the meeting, the extended format meeting took place. Present

at the meeting were, Deputy Minister of Foreign Affairs Battsetseg Batmunkh and Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to Turkey Bold Ravdan from the Mongolian side, and Minister of Economy Shahin Mustafayev and Deputy Head of the Foreign Policy Affairs Department of the Presidential Administration Hikmet Hajizadeh from the Azerbaijani side.

President Battulga pointed out that there is an enormous potential to enrich Mongolia-Azerbaijan relations with economic content, while requesting to cooperate in increasing bilateral trade and

investment and activating business-to-business ties. President Ilham Aliyev supported the proposal, and the sides agreed on sending a research team of the Ministry of Economy and business representatives of Azerbaijan to Mongolia in October, 2018.

investment and activating business-to-business ties.

President Ilham Aliyev supported the proposal, and the sides agreed on sending a research team of the Ministry of Economy and business representatives of Azerbaijan to Mongolia in October, 2018.

## President Battulga Khaltmaa invites Azerbaijani President Ilham Aliyev to Mongolia

President Ilham Aliyev also expressed his support toward the export of Mongolian products and goods to the Middle East through Azerbaijan.

The sides agreed to carefully study the matters of exporting animal-origin products, including meat and leather, to Azerbaijan, making an investment for the establishment of cashmere and wool processing and carpet factory that will provide jobs to 300 people in Mongolia, and bringing in the required technology from Azerbaijan. The heads of state had an elaborate discussion on bilateral cooperation in agriculture, tourism, education, sports, and transport sectors.

At the end of the meeting, President Battulga invited President Ilham Aliyev to Mongolia, and the latter expressed his appreciation of the invitation. [ZGM]

### SOCIETY

# IAAC comments on recent notorious cases

Independent Agency Against Corruption (IAAC) held a press conference yesterday and briefed on the on-going cases around the investment agreement of Oyu Tolgoi and MNT 60 billion sell-off of Mongolian People's Party during the Parliamentary Election.

## IAAC REOPENS MNT 60 BILLION SELL-OFF CASE

Regarding the MNT 60 billion sell-off of public administration positions, the IAAC announced that

the case was reopened on the basis of the Intelligence Agency report. The prosecutor's office previously decided to close the case due to lack of evidence. The investigation will be led by the General Intelligence Agency and comprise of the Police Authority and IAAC.

## INVESTIGATION FINDINGS OF OT AGREEMENT YET TO BE COMPLETED

Oyu Tolgoi Investment Agreement case, which involves

former high-profile officials such as former Prime Minister, Saikhanbileg Chimed, former Finance Minister Bayartsogt Sangajav, former Head of General Department of Taxation Ariunsan Baldanjav and former CEO of Erdenes Mongol LLC Byambasaikhan Bayanjargal, is still under investigation.

The IAAC spokesperson informed that several types of investigation will be conducted on OT case and was unable to give further details.

## FORMER CEO OF EMC IS UNDER INVESTIGATION OVER JUST GROUP CASE

A few years ago, Just Group LLC loaned a large amount of money from Standard Bank of Africa by collateralizing the EMC, which was filed to the international arbitration and ultimately suspended the EMC's foreign bank accounts.

Accordingly, the authorities at the time are currently under investigation. The prosecutor's

office requested to confine former CEO of EMC Ganzorig Chimiddorj as a suspect. The IAAC highlighted that after investigating for several years, it was discovered that the loan assets were allocated to the operations of related companies. Therefore, the assets of related individuals and entities are being exposed, recorded, suspended and reviewed. Aside from the former CEO, the IAAC is investigating four people related to the case. [ZGM]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "СХД, 15, 16, 17 дугаар хороо, нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засварын ажил /3 байр, 5 орц/"

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААФ-18/0091  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос "СХД, 15, 16, 17 дугаар хороо, нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засварын ажил /3 байр, 5 орц/"-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 2 жилийн (2016, 2017 он) борлуулалтын дундаж орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

**3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

**4. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх. Ижил төстэй ажилд барилга байгууламжийн дээврийн ажил болон түүнээс дээш гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

Огноо : 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

**Зураг төсөв боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.**

**Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:**

**1. 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш эсвэл 3Т-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш.**

**2. 1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв болон түүнээс дээш эсвэл**

**3Т-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв болон түүнээс дээш.**

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

**1. 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт болон түүнээс дээш, эсвэл**

**БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил болон түүнээс дээш.**

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. **Шаардахгүй.**

Тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810**



## Фото сурвалжилга

# Таны хүүхдийг аюул хаана ч отож байна

С.Батсайхан, Б.Батдорж  
ЗГМ

Золгүй гэхээс илүүтэйгээр насанд хүрэгчдийн хариуцлагагүй, хэнэггүй, амин хувиа хичээсэн өөдгүй хандлагын хар гайгаар өнгөрсөн зун олон хүүхэд эндэж, нийгмийг цочирдуулсан. Дараалан гарсан ослуудын дараа шийдвэр гаргагчдын зарим төлөөлөл ил задгай цахилгааны утсыг далдлах, сургууль, орон

сууцны орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг бүрдүүлэх чиглэлээр олон үүрэг даалгавар холбогдох албан тушаалтнуудад өгсөн. Харамсалтай нь, 1.1 сая гаруй хүүхэд багачуудынхаа аюулгүй байдлыг хангах, осол эндэгдлээс хамгаалах эл санаачилга гагцхүү цаасан дээр үлджээ.

Манай гэрэл зурагчид хүүхдэд ээлгүй нийслэлийн бодит төрхийг ийнхүү дуранд буулгажээ. [ЗГМ]



БГД-ийн 11 дүгээр хороо. Энхбаярын гэгдэх энэ замын огцом эргэлттэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал хэсэг нь тольгүй бас явган хүний замгүй.



БГД-ийн 18 дугаар хороо, 87 дугаар цэцэрлэгийн урд. 2012 онд 12 настай охины толгой дээр кран унаж, амь насыг нь бүрэлгэсэн. Харин өнөөдөр бид энэ гашуун сургамжийг мартжээ. Дахин тийм эмгэнэлт явдал болохгүй гэсэн баталгаа алга.



БГД-ийн 19 дүгээр хорооны 55 дугаар байрны хүүхдийн тоглоомын талбай. Гагнаас нь салж, хуучирч элэгдсэн тоглоомын талбай хүүхдэд осолдож, бэртэх нэг том шалтгаан болж байна.



БЗД-ийн 25 дугаар хороо, "Натур" худалдааны төвөөс Нарны зам руу гарах замд. Автомашин чөлөө завгүй давхилддаг эл зам бол олон зуун хүүхдийн сургуульдаа очих, гэртээ харих ганц жим.



БЗД-ийн 13 дугаар хорооны 118 дугаар байрны хойд тал. Оршин суугчид, хүүхдэд багачууд гэртээ орохын тулд хэзээ мөдгүй нурж унах гэж буй хашааны ёроолоор явахаас өөр аргагүй.



БГД-ийн 16 дугаар хороо, Модны-2. Бага насны хүүхдэд цахилгааны утсанд өртөж амиа алдсаны дараа ил задгай утсыг далдлах үүрэг дүүргүүдэд өгсөн. Гэвч үүнийг дүүргийн удирдлагууд үл тоож, томчууд эс анзаарч гагцхүү хүүхдүүд л юу юугүй өртөхөд ойрхон байна.



# Syndicated articles from FINANCIAL TIMES

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

## ББСБ-ууд Энэтхэгийн зах зээлийг сандаргав

Энэтхэгийн эрх баригчид 12.6 тэрбум ам.долларын эргэн төлөлтөд гарсан бэрхшээлийг шийдэхийг оролдож байна.> 10

## Google хайлтын системээ өмгөөллөө

Вашингтоны зүгээс нийгмийн сүлжээнд улс төрийн нэг талыг баримтлах хандлагын эсрэг дарамт шахалт нэмэгдэж буй. > 10

## Deutsche банк мөнгө угаахын эсрэг хяналтаа чангатгана

Германы санхүүгийн зохицуулагч BaFin агентлаг Deutsche банкинд хяналтын бие даасан аудитор томилсон байна. > 10

## ► Tesco Bank кибер халдлагын хэргээр торгуулав



Tesco банкинд кибер луйвартай холбогдуулан Их Британийн санхүүгийн зохицуулах байгууллага үнэмлэхүй торгууль оноох гэж байна. Бүр 2016 оны эцсээр дэгдсэн хэрэгтэй холбогдуулан оноох торгуулийн хэмжээг Их Британийн Санхүүгийн үйлчилгээний удирдах газар (FCA), Tesco-гийн банкны салбартай хэлэлцэж байгааг уг хэрэгт ойр эх сурвалж дамжуулав. Зохицуулагчид торгуулийн хэмжээг 30 сая фунт стерлингээр тооцжээ. Яриа хэлэлцээ тус банк IT тогтолцооны гацаа гажиг, кибер халдлагатай холбоотой хэд хэдэн хэрэгт орооцолдоод байгаа түвэгтэй үед өрнөж байна.

## ► Бодлогын хүү анх удаа инфляцын хэмжээнээс давав

АНУ-ын Холбооны Нөөцийн Банкны бодлогын хүүг сүүлийн арван жилд анх удаа төв банкны зорилтот инфляцын хувь үзүүлэлтээс давуу тогтоохоор боллоо. Хүү өсгөж шийдвэрийг энэ долоо хоногт зарлана. Холбооны Нөөцийн Банкны "илүүдэл" нөөцийг бусад банк, санхүүгийн байгууллагад ганц шөнийн хугацаагаар зээлдүүлсний төлбөр буюу бодлогын хүү нь төв банкны эрхэмлэдэг хэмжүүр болох АНУ-ын эдийн засгийн инфляцын хувь хэмжээнээс сүүлийн арван жилд анх удаа давах гэж байна. Төв банкны бодлогын хүү хамгийн сүүлд 2008 оны есдүгээр сард "Хувь хүний хэрэглээний зардлын" индексээс давж байжээ.

## ► Michael Kors компани Versace-г худалдаж авахаар хэлэлцэж байна



### Хавьер Эспиноза

АНУ-ын шилмэл бүтээгдэхүүний Michael Kors компани Миланы хувцас загварын Versace компанийг худалдан авах гэж байгааг яриа хэлэлцээнд ойр хоёр ч эх сурвалж мэдэгдэв. Хоёр тэрбум орчим ам.доллараар хэмжигдэж буй бизнесийн хэлцэлд Versace-ын цэвэр өр багтаж байгаа. Наймааг хараахан эцэслэн шийдээгүй байгаа тул Versace-д өөр худалдан авагчтай тохиролцох боломж байгааг эх сурвалж тайлбарлав.

Даваа гарагт газрын тос баррель нь 81 ам.доллар хүрсэн нь сүүлийн дөрвөн жилд тохиолдоогүй өндөр үнэ боллоо.



BBM©

# Газрын тосны үнэ дөрвөн жилийн дээд түвшинд хүрэв

◀ 1

Brent Лондоны арилжаагаар баррель нь 81.20 ам.доллар хүрсэн нь өдрийн дотор 2.40 ам.доллараар өссөн дүн болов. Энэ нь 2014 оны эцсээр олборлолт дэлхийн эрэлтээс хэтэрч үнэ эрс унаснаас хойш тохиолдоогүй өсөлт юм. Иранд тавьсан хориг бүрэн хэрэгжиж, нийлүүлэлт багасах ирэх оны эхээр баррелийн үнэ 100 ам.доллар давах байх хэмээн таваарын Tаfigurea биржийн нефтийн арилжаа хариуцсан тэргүүн Бен Люокот даваа гарагт Сингапурт болсон эрчим хүчний хуралдаан дээр анхаарууллаа.

*Хомсдоос үүдэн олборлогч нар газрын тосны гарцыг хуучин хязгаарт нь сэргээж баруулахаар зургадугаар сард шийдвэрлэжээ.*

Нью-Йоркод АНУ-ын газрын тосны бенчмарк West Texas Intermediate баррель нь 1.30 ам.доллараар үнэд орж 72.08 хүрсэн нь долдугаар сараас хойш тохиолдоогүй өсөлт юм. Нэг хэвийн нийлүүлэлтээс үүдсэн үнэ өсөлттэй холбогдуулан ноён Трамп Саудын Араб тэргүүтэй ОПЕК-ийн гишүүдэд олборлолт өсгөж үнэ баруулах шахалт үзүүлж байна. "Монопол ОПЕК үнэ бууруулах ёстой" хэмээн ноён Трамп пүрвэ гарагт Twitter-т жиргэжээ. Газрын тосны үнийн өсөлт арваннэгдүгээр сард болох дунд

хугацааны сонгуулиас өмнө дотоодын шатахууны зардалд тусгалаа олох вий хэмээн АНУ-ын албаны хүмүүс болгоомжлох боллоо. Дэлхийн гол олборлогч нар хэт нийлүүлэлтэд дарагдсан зах зээлд тэнцвэр тогтоохын тулд олборлолт өдөрт 1.8 сая баррелиар бууруулахаар 2016 оны эцсээр тохиролцсон. Гэтэл Венесуэлийн экспорт тасалдсаны дараа бусад улс олборлолт хэт багасгасан нь дэлхийн нийлүүлэлтийг хямраалаа. Хомсдоос үүдэн олборлогч нар газрын тосны гарцыг хуучин

хязгаарт нь сэргээж баруулахаар зургадугаар сард шийдвэрлэжээ. Ням гарагийн хуралдаанаар нефть экспортлогч орнуудын сайд нар олборлолтыг одоохондоо өнөөгийн түвшинээс хэтрүүлэх шаардлагагүй гэж үзсэн юм. Олборлогч нар зах зээлийн нөхцөлд нийцүүлэн олборлолт өдөрт нэг сая баррелиар нэмэгдүүлэх боллоотойг Саудын Арабын эрчим хүчний сайд Халид Аль Фалих бүр зургадугаар сард мэдэгдсэн ч хагас лутуу хэрэгжсэн. Эдүгээ Ираны экспортыг орлуулахын тулд гол олборлогч орнууд нийлүүлэлтээ хэр өсгөж чадах нь газрын тосны арилжаачид, эрчим хүчний салбарын шинжээч нарт асуулт болж хувирав. Газрын тосны зах зээлд нийлүүлэлт "тохиромжтой түвшинд

байгаа"-г ноён Фалих ням гарагт тайлбарлаж байлаа. Үнэ өссөн ч худалдан авагч нарын төлөө энэ удаад олборлолт өсгөх шаардлагагүй хэмээн сайд үзсэн юм. "Асуудлын учир нь олборлогч улсуудад биш, нэрэх үйлдвэрлэл эрхлэгчдэд, эрэлт хэрэгцээнд байгаа" хэмээн тэрбээр анхааруулав. Юутай ч нийлүүлэлт тасалдах, зах зээлд гэнэтийн өөрчлөлт үүсэх үед "шуурхай" хариу барих бодлого шаардлагатайг сайд хүлээн зөвшөөрч байв. **FT**

## Худалдааны дайны сүүдэр технологи үйлдвэрлэгчдийг дайрлаа

### Кэтрин Хилл

Тайбэйн айлууд даваа гарагт намрын дунд сарын ургацын баяр тэмдэглэж голын эрэгт шорлог шарангаа тэргэл сарыг харанхан амарцаалаа. Харин цахим үйлдвэрлэлийн Wistron компанийн менежерүүд амарсангүй. "Тайваньд эх хавтан үйлдвэрлэх шугам сэргээн тавих зардлын загвар туршиж байна. Үүний төлөө Трампд талархаж" хэмээн менежерүүдийн нэг өгүүлэв. Wistron нь бүхий л цахим бүрдлийг бэхлэх, холбох зориулалттай гол эд анги – PCB буюу хэлхээний хэвлэмэл хавтан үйлдвэрлэдэг. Тайванийн бусад үйлдвэрлэгчийн нэгэн адилаар тус компани бүр 1990-ээд оны эхээр доод түвшний технологи, хүн хүч шаарддаг үйлдвэрлэлээ бүгдийг нь БНХАУ-д шилжүүлжээ. Бүрдлүүдийг Хятад болон бусад

улсад нийлүүлэн угсарч нэг эд анги болгоод компьютер, сервер, ухаалаг утсанд ашигладаг юм. Хятадын эсрэг өрнүүлж буй ноён Трампын худалдааны дайны шинэ шат технологийн салбарыг үндсэндээ тойрч өнгөрсөн. Өнгөрсөн долоо хоногоос хэрэгжиж эхэлсэн уг шатанд Вашингтон БНХАУ-ын 200 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд 10 хувийн тариф тогтоосон юм. Гэхдээ зарим ханган нийлүүлэгч Хятадаас үйлдвэрлэлээ татахад төлөвлөж буйгаа үзэхэд хориг технологийн салбарын цогц бүтэцтэй ханган нийлүүлэх сүлжээнд занал учруулж байна. Хятадын экспортын хүчин чадлыг хараалж буй Вашингтоны дайралт хэтдээ АНУ-ын технологийн салбарт ашигтай хэмээн зарим шинжээч таамаглав. "Тариф технологийн нийт

*Үйлдвэрлэлээ эргүүлж татангаа өрсөлдөх чадвараа хадгалж үлдэх эзвэл илүү их хөрөнгө оруулахаас аргагүй*

салбарын арав орчим хувийг хамарсан. Харин компаниуд хориг яваандаа илүү өргөн цар хүрээг хамарна хэмээн одооноос болгоомжлох боллоо" хэмээн Credit Suisse-ийн хагас дамжуулагч үйлдвэрлэлийн судалгааны Тайвань дахь төвийн тэргүүн Рэнди Абрамс тайлбарласан юм. Dell, HP зэрэг технологийн группүүдийн борлуулдаг төрөл бүрийн серверийн олонхыг Wistron үйлдвэрлэдэг. Ийм серверийн эх хавтанг БНХАУ-ын Жуншаньд үйлдвэрлэж, АНУ-ын зах зээлд нийлүүлэх серверийг Мексикт угсардаг. Wistron-д "шинэ тариф ноцтой нөлөөлсөн"-ийг Тайбэй дахь технологийн судалгааны TrendForce компанийн шинжээч Марк Ли өгүүлж байлаа. Тайванийн бас нэг томоохон гэрээт үйлдвэрлэгч, зарим үйлдвэр нь Шанхайд ажилладаг Quanta Com-

puter ч АНУ-ын хоригт хохирогч нь. Тус компаниас Google, Facebook-д нийлүүлдэг серверүүдийн амин чухал олон бүрдлийн үнэ тарифаас болж өсөхөөр болжээ. Үүний өсөлтөөс үүдэн тус компани зарим үйлдвэрээ эргүүлээд Тайваньд шилжүүлэх талаар эргэцүүлж буйг ноён Ли дурдсан юм. Кабель, холбогч үйлдвэрлэгч Luxshare компани Вьетнамд үйлдвэрийн кампус байгуулж, Энэтхэгт шинээр үйлдвэр нээхээр судалгаа хийж байна. "Толгойн өвчин болж дууслаа" хэмээн Wistron-ы менежер бухимдсан нь үйлдвэрлэлээ эргүүлж татах шийдвэр хэр хүнд болохыг харууллаа. "Бид үйлдвэрлэлээ эргүүлж татангаа өрсөлдөх чадвараа хадгалж үлдэх гэвэл илүү их хөрөнгө оруулахаас аргагүй" хэмээн менежер тайлбарласан юм. **FT**

## Японтой хамт дэлхийгээ аварцгаая

### Шинзо Абэ

Энэ зун Японы өрнөдөд урьд хожид үзэгдээгүй их бороо асгарч, хөрс гулгаснаас 200 гаруй хүний амь эрдэж, олон зуун мянган хүн орон гэрээсээ хагаслаа. Үүнтэй зэрэгцэн улс орныг нэрвэсэн шатам халуун 160 орчим хүний аминд хүрэв. Төөнөсөн халуун агаар Умард Америк, Европ тивийг нөмөрч, хар салхи АНУ, Филиппинийг дайрлаа. Дэлхийн дулаарал нүүрс-төрөгчийн давхар ислийн ялгарлыг ихэсгэж, далай тэнгисийг хүчиллэг болгон, аяндаа цэнгэгших чадварыг нь муутгав. Далай тэнгис дэх ихэсгээр буй хуванцар хаягдал усан ертөнцийн экосистемд,

уламжлаад та бидний эрүүл мэндэд заналхийлж байгаа нь бүр ч хөнөөлтэй. Олон улсын хамтын нийгэмлэг уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлан зогсоох, алсыг харсан урт хугацааны арга хэмжээ авч ирэв. БНХАУ, Энэтхэгийг оролцуулаад дэлхийн бүх хүчирхэг эдийн засагтай улс орон 2015 онд Парис хотноо хэлэлцээр байгуулсан. Дараа жил нь урагшлах алхам болгон миний бие Японы Иса-Шима аралд зохион байгуулсан уулзалтаар G7-гийн гишүүн улсууд урт хугацааны стратеги боловсруулсан юм. Уур амьсгалын өөрчлөлт хөгшин залуу, хөгжингүй, хөгжиж буй бүх үеийнхний амь амьдрал

заналхийлж байна. Бэрхшээл бидний таамаглаж байснаас ч хурдан ноцтой болсоор. Иймд та бид илүү шийдмэг арга хэмжээг эрс шуурхай авах ёстой. Урагшлах зам тодорхой. Бид бүгд хөрс газрыг ногооноор нь, тэнгис далайг цэнхрээр нь хадгалж үлдэх ёстой. Тавьсан зорилго маань шинжлэх ухааны нэн шинэ мэдлэгт суурилах ёстой. Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Панельд (IPCC) оролцогч эрдэмтдийн хөдөлмөр бүтээл, дадлага туршлагад суурилан бүгд илүү ихийг ойлгож суралцахын хэрээр дэлхий нийтээрээ зохих арга хэмжээ авах болно.

Улс орон бүр онцгой байдлын ижил түвшинд ажиллах шаардлагатай. Олон Улсын Эрчим Хүчний Агентлагийн судалгаанаас үзвэл хүлэмжийн хийн ялгаруулалтаа ихэсгээгээр байгаа зарим улсаас шалтгаалж жил бүр хоёр тэрбум тонн хорт утаа агаарт ялгарч байна. Улс орон бүр амлалтаа ажил хэрэг болгох ёстой боллоо. Хөгжингүй орнууд хөгжиж буй улсууддаа амлалтаа биелүүлэхэд нь туслах хэрэгтэй байна. Урт хугацааны стратегид нийцүүлэн засгийн газрууд шинэ санаа түгэн дэлгэрэх, эдийн засгийн шинэ өсөлт үүсгэх инновацийг дэмжин тэтгэх нь чухал. ... Дэд бүтцээ үүсэлтэй ялгаруул

багасгах нь бас чухал. ... Эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ олборлодог тулшний хэрэглээг багасгах ёстой. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний ажиллагааг нь сайжруул гэсэн үг... Японд сүүлийн дөрвөн жилд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс гаралтай цахилгааны хэрэглээ 2.5 дахин нэмэгдсэн. Япон устөрөгчийн эрчим хүчний сэдвээр дэлхийн улс орнуудын сайд нарын уулзалт зохион байгуулах гэж байна. ... Хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийнхээ арга технологийг шинэчлэх цаг боллоо. Улс орнууд

хүлэмжийн хий ихээр ялгаруулж, зах зээлийн тэнцвэр алдагдуулж буй хэрээс хэтэрсэн төмөрлөгийн үйлдвэрлэлээ зогсоох ёстой... Уур амьсгалын өөрчлөлт, далай тэнгисийн бохирдол, гамшигийн эрдэлийг бууруулах ажил нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтын суурь юм. Африкийн хөгжлийн асуудлаарх олон улсын долдугаар хурал Японд чуулах үеэр бид тусламж дэмжлэгээ Африкийн улс орнуудад өргөжүүлэх болно. Энэхүү хүнд сорилтыг даван туулахад хамтран ажиллахыг бид дэлхийн бүх улс оронд уриалж байна. Уг материаллыг бичигч нь Японы Ерөнхий сайд. **FT**






хувь уруудлаа. Сүүлийн арван жилд IL&FS хэмээх бүртгэлгүй компани Энэтхэгийн дэдбүтцийн салбарт гол үүрэг гүйцэтгэж, зам, эрчим хүч, усны төслүүдэд зориулан корпорацийн өрийн зах зээлээс хэдэн тэрбумыг босгосон байна.

Энэ сард IL&FS группийн зээлдэгчдээс хэд хэд нь дампуурал зарласан явдал корпорацийн өрийн жижиг зах зээлд доржилт үүсэх нь гэсэн болгоомжлол төрүүлжээ. Гуравдугаар сарын байдлаар тус компани Энэтхэгийн корпорацийн өрийн зах зээл дэх төлөгдөөгүй өрийн гурван хувийг, банкны

нөхцөлийг бүр эмзэг болгов. Ambit Capital фирмийн шинжээчид зээлд суурилсан дундын сангууд руу мөнгө цутгаж байсан явдал банк бус зээлдүүлэгчдийг өрийн зах зээлийн хялбар нөхцөлд дасгажээ. Баасан гарагт Dewan Housing Finance компани богино хугацааны өрийн бичгээ алдагдалтай худалдаж байна гэсэн мэдээ тарахад хувьцааных нь үнэ 42 хувь унасан. Харин төлбөрийн чадвартайгаа баталсны дараа даваа гарагаас хувьцаа нь 11 хувь дээшилсэн байна. IL&FS-т тохиолдсон бэрхшээл Энэтхэгийн банк



## ББСБ-ууд Энэтхэгийн зах зээлийг сандаргав

Саймон Мунди

Энэтхэгийн эрх баригчид дэд бүтцийн нэг гол зээлдүүлэгчийн 12.6 тэрбум ам.долларын эргэн төлөлтөд үүссэн бэрхшээлийг шийдэхийг оролдож байна. Үүний улмаас тус улсын банк бус санхүүгийн зах зээлийн тоглогчид хувьцаагаа яаралтай зарах нь эрчимжиж, хөрөнгийн нийт зах зээлд халдварлаж болзошгүй түгшүүр үүслээ. Даваа гараг

хүртэл Энэтхэгийн Nifty индекс таван өдөр дараалан унасан бол тухайн өдрөө 1.5 хувь доошилсны дотор банк бус зээлдүүлэгчид хамгийн их хохирол амсав. Салбарын томоохон компаниудын нэг Infrastructure Leasing & Financial Services зээлийн дампууралд ойртсон аж. Үүний улмаас Nifty индекс сарын өмнөхөөс долоон хувиар уналаа. Зохицуулагчид нэгдсэн арга

хэмжээ авсан ч уналтыг зогсоож чадсангүй. Ням гарагийн орой Энэтхэгийн Нөөцийн банк болон Үндэсний үнэт цаасны агентлаг хамтарсан мэдэгдэл гаргаж, “Санхүүгийн зах зээл дэх үйл явцыг нарийн ажиглаж байна. Шаардлагатай бол зохих арга хэмжээ авна” гэсэн амлалт өгчээ. Сангийн сайд Арун Жайтли мөн банк бус зээлдүүлэгчдийн төлбөрийн чадварыг дэмжихийн

тулд чадах бүхнээ хийнэ гэжээ. Гэвч даваа гарагт хөрөнгийн бирж нээгдэхэд хөрөнгө оруулагчид банк бус зээлдүүлэгчдийн хувьцааг зарсаар байсан агаад Bajaj Finance, HDFG, Indiabulls Housing зэрэг томоохон компаниудын хувьцааны үнэ зургаан хувиар доошлов. Банкуудын хувьцаа бас цохилтод өртөж, Nifty-гийн банкны индекс долоо хоногийн өмнөхөөс найман

зээлийн 0.5 хувийг эзэмшиж байсныг Moody’s-ын тайланд дурдсан. Дампуурлууд дотоодын зэрэглэлийн агентлагуудад итгэх итгэлийг сэвтүүллээ. Хөрөнгө оруулагчид сандралд орж, тогтмол ашигтай дундын сангаас мөнгөө татаж эхэлсэн тул сангийн менежерүүд төлбөр хийхийн тулд эзэмшлээ худалдаж байгаа нь банк бус зээлдүүлэгчдийн санхүүжилтын

бус нэгжүүдийн загварт бий болсон богино хугацааны зээлээр урт хугацааны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эрдэлийг илрүүллээ хэмээн Credit Suisse-ийн шинжээчид анхааруулав. Тэд “Банк бус санхүүгийн компаниудын хөрөнгө ба авсан өрийн зөрүү нэмэгдэж буйд анхаарах цаг болсон” хэмээн дүгнэсэн байна.



## Google хайлтын системээ өмгөөллөө

Ричард Уотерс

Вашингтоны зүгээс улс төрийн нэг талыг баримтлах хандлага болон хувийн мэдээллийн хадгалалтын талаар дарамт шахалт нэмэгдэж буй үед Google компани өөрийн хамгийн давуу салбар руу анхаарлыг нь шилжүүлэхийг эрмэлзэж байна. Тухайлбал, өөрийн үндсэн хайлтын системд гарсан дэвшлийг танилцууллаа. Компанийн захирлууд хувийн мэдээллийг хамгаалах хэд хэдэн шинэ арга зарласан боловч улс төрийн хайчинд ороод буй асуудлаас зайлсхийв. Сенатын тагнуулын хороо интернет хайлтын компани сонгуульд хөндлөнгөөс оролцсон асуудлаар өнгөрсөн сард болсон хэлэлцүүлэгт захирлуудаа ирүүлээгүй хэмээн шүүмжилсэн.

Ерөнхийлөгч Дональд Трамп Хууль зүйн яаманд хандаж, Google Бүгд найрамдах намын эсрэг байр суурь баримталж буй эсэх асуудлаар мөрдөн байцаалт явуулахыг уриалжээ. Даваа гарагт хайлтын системийн захирал Бен Гомес хэлэхдээ Google бие даасан туршигчдыг ажиллуулж, программаа нэг талыг барихгүй байхад чиглүүлнэ хэмээн

мэдэгдэв. Тусгай удирдамжийн дагуу ажиллах туршигчид компанийн инженерүүдийн дур зоргоор хийх хайлтад өөрчлөлт хийхгүй байхад чухал үүрэг гүйцэтгэх аж. Тэд энэ онд 200 мянган удаа сорилт явуулснаас 25 хувьд нь хайлтын алгоритмыг өөрчлөх шийдвэрт хүрсэн гэж ноён Гомес онцолсон байна. Тэрбээр Сан Францискод хийсэн танилцуулгадаа “Хайлт төгс биш, бид тийм бодлоор өөрсдийгөө хуурдаггүй. Гэхдээ бидний үүрэг бол өдөр бүр түүнийг сайжруулах явдал юм” хэмээн мэдэгдэв. Зарим захиралтай хувиараа ярилцахад Цагаан ордны шүүмжлэл нь компани хэрхэн ажилладагийг ойлгоогүйгээс болсон гэж үзэх хандлага ажиглагдсан. Тэд Google хайлтын алгоритмаа шинэчилснээр үйлчилгээнээс авч буй үр дүнд ямар өөрчлөлт гарсныг хэрэглэгчдэд тайлбарлах шаардлагатай гэж ярьсан юм.

Google-ын ерөнхий захирал Сундар Пичай дотоод мэйлдээ улс төрийн нэг талыг барьж байгаа гэх шүүмжлэлийг няцаажээ. Тэрбээр “Компани улс төрийн зорилгын төлөө хайлтынхаа

найдвартай байдлыг бусниулдаг гэж үзэх нь худал зүйл” хэмээн бичсэн байна. Гэвч өнгөрсөн онд мусульманчуудыг АНУ-д орохыг хориглох үеэр исламын эсрэг үзлийг шүүмжлэх үүднээс компанийн хайлтын платформыг ашигласан гэж компанийн зарим ажилтан ярьсан. Ноён Пичай энэ талаар дотоодын санал шүүмжлэл үйлчилгээг өөрчлөхөд хүргээгүй гэж мэдэгдэв.

Google-ийг олон жилийн турш хайлтын үр дүнг гуйвуулах буюу нэг тийш хэлбийлгэдэг гэсэн шүүмжлэл тасрахгүй байгаа. Үүний нэг жишээ болгож еврей гэж бичихэд араас нь гэм нүгэл гэдэг үг дагалдан гарч ирдэг тохиолдлыг ярьдаг. Тус компани ийм алдааг засахын тулд эхлээд туршигчдаар алгоритмын өөрчлөлтийг шалгуулж байгаа гэнэ. Тухайлбал, буруу тийш хөтлөх мэдээллийг хааж, зөв тийш чиглүүлэх өөрчлөлт оруулсан боловч хайлт удаахрах боломжтой. Даваа гарагт Google хайлтын системийнхээ 20 жилийн ойгоор зөвхөн энгийн хайлтын үйлчилгээнээс ахиж, ямар шинэ зүйл хийх гэж буйгаа танилцуулсан юм.



## Deutsche банк мөнгө угаахын эсрэг хяналтаа чангатгана

Олаф Сторбек

Германы санхүүгийн зохицуулагч BaFin агентлаг Deutsche банкинд хандаж, мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг даалгаснаас гадна ирэх гурван жилд ахиц гарах эсэхийг хянах бие даасан аудитор томилсон байна. BaFin тус банкны байнгын аудитор KPMG компанид 36 сарын хяналтын эрх олгож, эргэж тайлагнах үүрэг өгөв. АНУ, Их Британийн мөрдөн байцаагчид Оросоос гаралтай 10 тэрбум ам.долларыг Германы хамгийн том зээлдүүлэгчээр дамжуулан угаасан гэх хэргийг илрүүлж, 630 сая ам.доллар төлөхөөр тохиролцсоноос хойш жил өнгөрсний дараа ийм шийдвэр гарлаа.

BaFin анх удаа уг зорилгоор хөндлөнгийн хянагчийг томилсон байна. 2016 онд Британийн Санхүүгийн зохицуулалтын захиргаа Deutsche банкинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон хоригийг хэрэгжүүлэх журмыг ноцтой

бөгөөд системтэйгээр зөрчиж байгаа тухай анхааруулга өгсөн аж. BaFin даваа гарагт хийсэн мэдэгдэлдээ “Deutsche банк одоо дотоодын зохих хамгаалалт, ерөнхий журмын нарийн хэрэгжилтийг нэвтрүүлэх хэрэгтэй” гэж дурдсан байна.

Зохицуулагч агентлагийн шийдвэрийг мэдэх эх сурвалж Financial Times сонинд ярихдаа тус банкны журам хэрэгжүүлэлт удааширсан тул зохицуулагчдын гэвчээр алдарсан байх хэмээн тайлбарлав. Deutsche банкны нэг ахлах ажилтан энэ талаар BaFin-ы шийдвэр зохицуулагчид банкинд итгэл алдсаныг харуулж байгаа боловч ийм арга хэмжээг бусад оронд ч түгээмэл ашигладаг гэв. Өөр хоёр эх сурвалжийн бидэнд хэлсэнээр саяын шийдвэр ямар нэг зөрчлөөс үүдээгүй бөгөөд Данийн Danske банкны Эстонийн салбараар 200 тэрбум ам.доллар угаасан хэрэгтэй холбоогүй аж. Наймдугаар сард Reuters агентлаг Deutsche банк үйлчлүүлэгчдэд шалгах тал дээр дутагдалтай байгааг мэдээлсэн. Тус банкны

нэг ажилтан үйлчлүүлэгчдийн 95 хувийг автоматаар шалгадаг боловч Орос, Ирланд, Испани, Итали, Өмнөд Африк улсуудад гар аргаар хяналт гүйцэтгэдэг хэмээн ярьжээ. Оросын үйлчлүүлэгчдийн хувьд хяналт сайжирч, энэ зунаас баримтын 67 хувийг автоматаар шалгадаг болсон байна. Deutsche банкны төлөөлөгчийн ярьснаар хэрэглэгчийн мэдээллийг 100 хувь гар аргаар шалгахад энэ зун зарим талаар дутагдал илрэсэн боловч цаашдаа гараагүй аж.

Тус банкны мэдэгдэлд “Манай банк BaFin болон KPMG-ийн төлөөлөлтэй нягт хамтран ажиллаж, зохицуулалтын шаардлагыг аль болох түргэн, үйл ажиллагаанд багтаан хэрэгжүүлнэ” гэж онцолжээ. Энэ оны эхээр Deutsche банкны АНУ дахь салбар санхүү, менежмент, үйл ажиллагаанд багтаан хэрэгжүүлнэ” гэж онцолжээ. Энэ оны эхээр Deutsche банкны АНУ дахь салбар санхүү, менежмент, үйл ажиллагаанд багтаан хэрэгжүүлнэ” гэж онцолжээ. Энэ оны эхээр Deutsche банкны АНУ дахь салбар санхүү, менежмент, үйл ажиллагаанд багтаан хэрэгжүүлнэ”-ад ороод байгаа юм.





## Эдийн засаг

# ₮900 мянгаас доош орлоготой өрх 10 хувиар хорогдсон

**Валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгосон**

Ч.Дүйриймаа  
ЗГМ

Монголбанкны бодлогын хүүг хэвээр үлдээх шийдвэр болон валютын ханшийн өөрчлөлтийн улмаас эдийн засагт учирч болзошгүй эрсдэлийн талаар СЭЗИС-ийн багш, эдийн засагч Ж.Дэлгэрсайхантай ярилцлаа.

**-Монголбанк бодлогын хүүг хэвээр үлдээсэн нь хэр оновчтой гэж бодож байна вэ?**

-Монголбанк 2017 оноос хойш хоёр гурван удаа бодлогын хүүгээ бууруулсан. Харин энэ удаад бодлогын хүүг хэвээр үлдээх шийдвэр дахин гаргалаа. Би энэ шийдвэрийг бага зэрэг гайхсан. Өнөөгийн эдийн засгийн ерөнхий дүр зургийг харвал, нэлээн эрдэлтэй нөхцөл байдал руу орж байна. Эдийн засагт бага зэрэг халалт үүсэх магадлалтай байна. Оны сүүлээр эрдэл үүсч болзошгүй учраас мөнгөний бодлогын хүүг бага зэрэг өсгөх хэрэгтэй гэж бодож байна. Ингэснээр эрдэлээс хамгаалж, эдийн засагт тодорхой хэмжээний болгоомжлох дохио өгөх байсан болов уу.

**-Цаашид валютын ханш хэр зэрэг өсөх хандлагатай байна вэ. Он дуустал тогтвортой байх болов уу?**

-Валютын ханшийн өсөлт үндсэн хоёр шалтгаантай. Өнөөг хүртэл эдийн засгийн ерөнхий бүтэц, валютын ханшийн тогтвортой байдал болон орох, гарах урсгалын тэнцвэртэй системийг бий болгож чадаагүй. Тиймээс эдийн засгийн идэвхжилийн үед валютын орох урсгал тэнцвэрээ алдаж ханш нь өсдөг. Удаах шалтгаан нь Америк Хятадын хоорондох худалдааны үл ойлголцлоос үүдсэн ам.долларын ханшийн өсөлт юм. Энэ нь Хятад төдийгүй дэлхийн

зах зээлд ихээхэн нөлөөлж байгаа. Валютын ханшийн өнөөгийн нөхцөл байдал цаашид үргэлжлэх төлөвтэй байна. Учир нь валютын ханшийн орох урсгалыг дэмжих гол суваг нь экспорт. Валютын ханшийн өсөлт цаашдаа ямар байх нь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжилтээс шалтгаална.

**-Монголбанк инфляцыг найман хувьд барих зорилт тавьсан. Энэ зорилтоо биелүүлж чадах болов уу?**

-Инфляц зорилтот түвшнээс давна гэж бодож байна. Гэхдээ наймдугаар сарын инфляцыг өмнөх сартай харьцуулахад зорилтот түвшнээс хол давахааргүй буюу харьцангуй буурсан үзүүлэлттэй байсан. Гэхдээ энэ нь хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангах худалдан авалт, гадаад дотоодын оюутны хөдөлгөөнөөс хамаарсан бөгөөд өөрөөр том өөрчлөлт гараагүй. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс хамаарч өндөр өсөөгүй. Хэрэв энэ байдлаараа байвал газар тариалангийн салбарын ургац хураалттай холбоотой эрдэл бодож, оны сүүлчээр инфляц зорилтот түвшинг давах болов уу гэсэн хүлээлт саармагжих юм.

### Эрэлтийн шинжтэй инфляцыг бодлогын хүүгээр зохицуулна

**-Монголбанк аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгохоор шийдсэн. Ийм аргачлал хийх нь хэр тохиромжтой вэ?**

-Өнгөрсөн хавар валютын эрэлтийг дэмжихгүйн тулд төгрөгийн заавал байлгах нөөцийг 1.5 нэгжээр бууруулсан. Үүнийг банкуудын эх үүсвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн



С.Батсайхан / ЗГМ©

гэж бодож байна. Харин валютын зээлийн эрсдэлийг эрсдэлийн түвшинд 150 хувиар тогтоосон. Ингэснээр валютаар зээл авах нөхцөл болоод валютын зээлийг хаах боломжийг нь харьцангуй нэмж банкинд ирэх дарамт багасах нөлөөтэй гэж үзэж байгаа.

**-Эдийн засгийн идэвхжилийн үр өгөөж нь иргэдийн орлого болоод өрхийн хэрэглээнд бодитой нөлөөлж байгаа юу?**

-Өнөөгийн эдийн засгийн өсөлт чухам хэнд хүрч буй нь тус эргэлзээтэй. Монгол Улсын хувьд нэрлэсэн цалин, ДНБ болон төсвийн үзүүлэлт 2010 оноос хойш дариу 2.6-

2.7 дахин өссөн. Гэвч нийт иргэдийн амьжиргааны чанар энэ хэмжээнд өсөөгүй л байна. Иймд нөхцөл байдал 2016 оныг хүртэл нэлээн доройтсон ч сүүлийн хоёр жилд өрхийн орлого, зарлагын бүтэц харьцангуй нэмэгдсэн. 900 мянга ба түүнээс дээш орлоготой өрхүүдийн бүтэц сайжирсан. 900 мянгаас доош орлоготой өрх харьцангуй багасаж байна. Эдийн засаг зургаан улирал дараалан 4-6 орчим хувийн өсөлттэй байсан өрхийн амьжиргаанд эерэгээр нөлөөлж эхэлж байна. Өөрөөр хэлбэл, нэг саяас дээш орлоготой өрх 10 гаруй хувиар өссөн. Энэ нь 900 мянгаас доош орлоготой өрхүүдийн хорогдсон хувьтай

дүйцэхүйц байна. Ерөнхийдөө өрхийн орлогын нэрлэсэн түвшин харьцангуй сайжирч байна гэсэн үг.

**-Хүнсний инфляцыг хянаж, үнийг тогтвортой байлгаж боломжтой юу?**

-Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжиж байх үед Монгол Улсын инфляцын шалтгаан нийлүүлэлтийн чанартай инфляц байсан. Ийм инфляцыг багасгах үүднээс үнэ тогтворжуулах хөтөлбөр, нөөцийн мах гэсэн ойлголтууд бий болгосон. Энэ нь тодорхой хэмжээгээр хүнсний инфляц нөлөөлж чадсан гэж үздэг. Одоогоор эдийн засаг сэргэж нийлүүлэлтийн шинжтэй инфляц алга боллоо гэхэд эрэлтийн шинжтэй инфляц дахин үүсэх магадлалтай. Учир нь 2016 он хүртэл иргэдийн худалдан авах чадвар доройтож, буурсан. Харин эдийн засаг сэргэсэнээр худалдан авалт ч мөн сэргэж байна. Иймд эрэлтийн шинжтэй инфляцыг мөнгөний бодлогын хүүгээр зохицуулах боломжтой. Энэ нь мөнгөний нийлүүлэлтийг бага зэрэг хязгаарлах арга зам юм.

**-Бизнесийн салбарынхан өнөөгийн нөхцөл байдалд ямар бодлого баримтлах хэрэгтэй вэ?**

-ҮСХ-ны мэдээллээр ажилтантай аж ахуйн нэгжүүд 1-9 болон 199-ээс дээш ажилтантай гэж хуваагддаг. Эдийн засгийн өсөлт томоохон аж ахуйн нэгжүүдэд илүү их нөлөөлдөг. Жижиг, дунд аж ахуйн нэгжид бизнесийн сэргэлт хүчтэй нөлөөлж чаддаггүй. 2017 онд томоохон аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлтийн хэмжээ дунджаар 30-50 орчим хувиар өссөн. Тэргүүлэх чиглэлийн аж ахуйн нэгжүүд хүний нөөцийн бодлогоороо цалингийн асуудлыг зохицуулах нь зүйтэй. Мэдээж эдийн засгийн тэлэлтийн үед тэргүүлэх аж ахуйн нэгжүүд эхэнд явдаг. Харин Монголын хамгийн том ажлын байрыг бий болгодог жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн цалинг нэмэх боломж хязгаарлагдмал хэвээр байна. [ЗГМ]

### УУЛ УУРХАЙ

## Төсвийн орлогын 26 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна

Өнгөрсөн сарын байдлаар төсвийн нийт орлогын 26 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” компани оны эхний найман сард 222.6 тэрбум

төгрөгийн татвар төвлөрүүлж, өмнөх оны мөн үеэс 40 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Харин “Оюу Толгой” компани 275.4 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн

үеэс 37 хувиар өссөн байна. Тус хоёр компанийн төлсөн татварын хэмжээ уул уурхайн салбарын төвлөрүүлсэн татварын 30 орчим хувийг дангаараа эзэлж байна. 2013-2015 онд уул уурхайн

салбар төсвийн орлогын 21-22 хувийг, 2016 онд 16 хувийг бүрдүүлж байсан бол сүүлийн хоёр жилд энэ үзүүлэлт өсөж байна. Харин энэ жилийн тайлант хугацаанд төсвийн нийт

орлого, тусламжийн дүн 6.4 их наяд төгрөгт хүрчээ. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 410 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “СХД, 12, 14, 15 дугаар хороо, нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засварын ажил /3 байр, 5 орц/”

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-18/0092  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос “СХД, 12, 14, 15 дугаар хороо, нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засварын ажил /3 байр, 5 орц/”-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn, хаагаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 2 жилийн (2016, 2017 он) борлуулалтын дундаж орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
  - 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.
  - 3. Сүүлийн үеийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.
  - 4. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.
- Ижил төстэй ажилд барилга байгууламжийн дээврийн ажил болон түүнээс дээш гүйцэтгэсэн туршлагыг тооцно. Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

**Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.**

**Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:**  
**1. 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)** болон түүнээс дээш эсвэл  
**ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)** болон түүнээс дээш.  
**2. 1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв** болон түүнээс дээш эсвэл  
**ЗТ-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв** болон түүнээс дээш.

**Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.**

**1. 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт** болон түүнээс дээш, эсвэл  
**БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил** болон түүнээс дээш.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. **Шаардахгүй.** Тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 30 минут**аас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 15 цаг 00 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.

Сонирухсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаагаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810**

### ЗГМ ТОВЧХОН

**» АРИЛЖАА**  
Монголын хөрөнгийн бирж даваа гарагийн үнэт цаасны арилжаагаар 23 хувьцаат компанийн 416,608 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр долоон хувьцаат компанийн хувьцааны ханш өсөж, 14 компанийнх буурсан бол хоёр компанийн ханш тогтвортой байлаа.

81.4

Ам.доллар. Лондоны биржийн даваа гарагийн арилжаагаар арваннэгдүгээр сарын фьючерс хэлцлийн үнэ 3.4 хувиар өсөж, нэг торх нь гүүлийн дөрвөн жилийг хугацаанд анх удаа 81.4 ам.долларт хүрчээ.

### » ИНДЕКС

0.39

Хувь. Топ 20 индекс 19864.7 нэг болж, 0.39 хувиар буурлаа. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 2.3 их наяд төгрөгтэй тэнцлээ.

### » ХУВЬЦАА

Энэ өдөр “Хөвсгөл алтан дуулга” болон “Материалимпекс” компанийн ханш хамгийн өндөр өсөлттэй байв. Харин “Э-Транс Ложистикс” болон “Так-Ко” компанийн хувьцаа хамгийн их уналттай байлаа.

### » ХӨРШ

43.5

Тэрбум юань. БНХАУ “Намрын дунд сарын баяр”-аараа 97.9 сая жуулчин хүлээн авчээ. Ийн дотоодын аялал жуулчлалын орлого нь 43.5 тэрбум юань буюу 6.34 тэрбум ам.долларт хүрчээ.

9.8

Хувь.БНХАУ ирэх сараас худалдааны найдвартай түншүүддээ импортын татварын хөнгөлөлт үзүүлэх бөгөөд импортын дундаж татварын хэмжээ нь 9.8 хувьтай байдаг байна. Ийн хөнгөлөлт үзүүлснээр дотоод хэрэглээг эрчимжүүлэх, эдийн засгийн өсөлтөө дэмжих боломжтой юм.

### » ГАЗРЫН ТОС

1.14

Хувь. WTI төрлийн газрын тосны ханш 1.14 хувиар өсөж, 71.89 ам.долларт хүрчээ.

### » НҮБ

5-7

Их наяд ам.доллар. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд жил бүр 5-7 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай.

### ВАЛЮТЫН ХАНШ

|               |          |
|---------------|----------|
| АНУ-ын доллар | 2,533.95 |
| Евро          | 2,977.01 |
| Японы иен     | 22.44    |
| ОХУ-ын рубль  | 38.42    |
| БНХАУ-ын юань | 368.72   |
| БНСУ-ын вон   | 2.26     |



## Эдийн засаг

### Уул уурхай бол бизнесийн үржил шимтэй хөрс

Эдгээрийг дотоодоос худалдан авахад төлбөр нь эдийн засгийн хөдөлгөгч болж, ажлын байр хадгалж, өрхийн амьдралд нааштайгаар нөлөөлж байдаг билээ.

Олборлох салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэхээс гадна олон улсын бизнесийн мэдлэг, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд түлхэц өгдөг. Энэ жишгийг өөртөө агуулсан төслүүдийн нэг нь “Тавантолгой”.

Монголын экспортын нүүрсний 30 хүртэлх хувийг дангаар бүрдүүлж буй “Эрдэнэ Тавантолгой” уг төслийн толгой нь. Тус компани 2017 онд нүүрс тээврийн чиглэлээр төрийн 10, хувийн хэвшлийн 40 гаруй аж ахуйн нэгжтэй хамтран ажиллажээ. Ингэснээр тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд болон хил, гааль, авто замын салбарт 2500 орчим ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлжээ.

“Эрдэнэ Тавантолгой”-н нийт ажилтны 20 гаруй хувийг орон нутгийн иргэд бүрдүүлдэг. Улсын төсөвт 2017 онд 23.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, 506 сая төгрөгийн шууд худалдан авалт хийжээ. Төрийн өмч давамгайлсан, Засгийн газар солигдох бүрт удирдлагын баг нь үндсээрээ өөрчлөгддөг “Эрдэнэ Тавантолгой” үйл ажиллагаа явуулснаар бизнест жилд хагас тэрбум төгрөг зарцуулж байна. Энэ бол нэг компанийн шууд худалдан авалтын хаялга. Тэгвэл нээлттэй буюу зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтаар нийт 5.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ.

Уул уурхайн ордууд шил



Төсөвт бүрдүүлж буй татвар, хураамж, төлбөрөөр уул уурхайн төслийн өгөөж хязгаарлагдахгүй.

С.Батсайхан / ЗГМ ©

# Нүүрсний компаниуд бизнесийг их наядаар тэтгэдэг

шилээ даран эдийн засгийн эргэлтэд орж, Монголыг чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт цутгаж эхэлсэн 2011 оноос хойш уул уурхайн салбарт ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэд ипотекийн зээлд хамрагдах нь эрс нэмэгдсэн байдаг. МИК-ийн мэдээллээр, 2017 оны байдлаар орон сууцны зээлтэй иргэдийн тав орчим хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байна.

Үндсэндээ нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын худалдан авалт нэг

их наяд төгрөгт хүрч буй бөгөөд бизнесийн хэрэглэгч болж байна.

**“Эрдэнэ тавантолгой” 2017 онд 506 сая төгрөгийн худалдан авалт хийжээ**

Эдгээр компанитай бизнесийн хамтрагч, түнш байх нь тухайн

компани, жижиг дунд үйлдвэр эрхлэгч тэлэх, ажилтай, орлоготой байхад эерэг нөлөө үзүүлдэг аж.

“Эрдэнэ Тавантолгой”-д гэрээт олборлолтын үйлчилгээ үзүүлдэг “Хишиг Арвин Индустриал” 2018 оны тавдугаар сарын байдлаар 1400 орчим ажилтан, 600 гаруй техник, тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа явуулж байна. 20 жилийн түүхтэй тус компани сүүлийн 10 жилийн хугацаанд хүний нөөц болон техникийн хүчин чадлаараа эрс ялгарах

болсон. “Саусгоби Сэнде”-ийн Овоот, “Эрдэнэ Тавантолгой”-н Баруун, Зүүн цанхи, “Оюу-толгой”-н далд уурхай зэрэг томоохон төслүүдэд гэрээт олборлолтын үйлчилгээ үзүүлж, энэ хэрээр тус компанийн цар хүрээ өргөжжээ.

Түүнчлэн орон нутгийн өмчит “жижиг” хэмээн тодотгодог “Тавантолгой” компани дээрх компаниудаас дутахгүй бизнест дэмжлэг болж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар өөрийн үндсэн 197 ажилтнаас гадна туслан гүйцэтгэх

компанийн нийт 1300 орчим хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулжээ.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж, эндээс “бойжсон” үндэсний хэмжээний компаниуд бизнесээ төрөлжүүлж, хөдөө аж ахуй, барилга, дэд бүтэц, банк, санхүү, аялал жуулчлалын салбарт хэдийнэ хөл тавьсан. МАК, “Гацуурт”, “Монполимет” бол үүний тод жишээ. Уул уурхайн бизнест үржил шимтэй хөрс, шинэ бизнест үржих бордоо, хур болж байна. [ЗГМ]



**DeLonghi**  
Кофе чанагч  
ICM-2.1B

**1,500 ОНООНЫ БЭЛЭГ**

# MEGA SALE

IX/07 - X/07  
УРАМШУУЛАЛТ ХУДАЛДАА

ОНООГОО  
ЦУГЛУУЛААД  
БЭЛГЭЭ СОНГО



**CANDY**  
Бүрэн автомат угаалгын машин

**9,000 ОНООНЫ БЭЛЭГ**



**Panasonic**  
Ус буцалгагч

**1,500 ОНООНЫ БЭЛЭГ**



**SONY**  
40" HD KDL-40W650D

**10,000 ОНООНЫ БЭЛЭГ**



**Panasonic**  
Индүү

**1,500 ОНООНЫ БЭЛЭГ**



**SHARP**  
Мини бар хөргөгч

**3,000 ОНООНЫ БЭЛЭГ**



**KENWOOD**  
Махны машин

**3,000 ОНООНЫ БЭЛЭГ**

Худалдан авалтын 500,000 төгрөг тутамд хусч арилгадаг сугалаа сугалан оноо цуглуулж, 30 гаруй брэндийн бэлэгнээс сонгоорой.

Facebook: /BSBServiceOfficial

Phone: 77220272

BSB

Better Lifestyle